

**ЛэндМН ББСБ ХХК**

(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуй нэгж)

Аудитлагдсан Санхүүгийн Тайлан

2017 оны 10 дугаар сарын 31

## АГУУЛГА

### ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

#### Хараат бус Аудиторын Тайлан

Ашиг алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан .....	1
Санхүүгийн Байдлын Тайлан .....	2
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан.....	3
Мөнгөн Гүйлгээний Тайлан .....	4

#### Санхүүгийн тайлангийн тодруулгууд

Санхүүгийн тайлангийн тодруулгууд .....	1
1 Компанийн талаарх мэдээлэл.....	5
2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого .....	5
3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон Толилуулгад орсон өөрчлөлтүүд ..	12
4 Нягтлан бодох бүртгэлийн гол тооцооллууд болон үнэлэмжүүд .....	15
5 Хүү болон түүнтэй адилтгах цэвэр орлого ба Сегментийн мэдээлэл .....	15
6 Удирдлагын болон үйл ажиллагааны зардал .....	16
7 Орлогын албан татвар .....	17
8 Нэгж хувьцаанд ногдох ашиг.....	18
9 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө .....	18
10 Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа .....	19
11 Биет бус хөрөнгө .....	20
12 Үндсэн хөрөнгө .....	21
13 Бусад хөрөнгө .....	21
14 Хаалттай бондын өглөг .....	22
15 Бусад өр төлбөр .....	22
16 Хувьцаат капитал .....	22
17 Санхүүгийн Эрсдлийн Удирдлага .....	23
18 Болзошгүй өр төлбөр ба Үүрэг хариуцлага.....	28
19 Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт .....	29
20 Холбоотой талын ажил гүйлгээ.....	29
21 Тайлагналын өдрийн дараах үйл явдал .....	31
22 Өмнөх хугацааны үлдэгдлийн дахин тайлагнал .....	32
23 Монгол хэл дээрх орчуулга .....	32

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ЛэндМН ББСБ ХХК-ийн (өмнө нь “Дуусашгүй Ундарга ББСБ ХХК” нэртэй байсан) /цаашид “Компани” гэх/ Гүйцэтгэх захирал **Махвал овогтой Түвшинжаргал**, компанийн санхүүгийн удирдлагыг хариуцан ажилладаг ерөнхий нягтлан бодогч **Дэмбэрэлдовд овогтой Отгонгэрэл** бид 1-ээс 32 дугаар хуудаснаас бүрдсэн энэхүү санхүүгийн тайлан нь 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал болон мөн тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант 10 сарын хугацааны үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн болохыг үүгээр мэдэгдэж байна.



М.Түвшинжаргал  
Гүйцэтгэх Захирал

  
Д.Отгонгэрэл  
Ерөнхий Нягтлан Бодогч

Огноо: 2017 оны 12 дугаар сарын 8

## **ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

### **ЛэндМН ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчид**

---

#### **Дүгнэлт**

Бид ЛэндМН ББСБ ХХК ("Компани")-ийн 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон арван сарын хугацааны ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон арван сарын хугацааны үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"-ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

#### **Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг дүнг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.



Building a better  
working world

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

### ЛэндМН ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчид

#### Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлттэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.



Building a better  
working world

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

ЛэндМН ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчид

### Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

### Бусад

Компанийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн аудитыг өөр аудитор гүйцэтгэж, уг тайланд 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдөр зөрчилгүй дүгнэлт гаргасан байна.

Санхүүгийн тайланд тусгагдсан 2016 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон 10 сарын хугацааны ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, санхүүгийн байдлын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон холбогдох тайлбар тодруулгууд аудитлагдаагүй болно.

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, талуудын хооронд байгуулсан аудитын ажлын гэрээт захидалд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



*Ernst & Young Mongolia Audit LLC*

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК  
Мэргэшсэн нягтлан бодогчид

Улаанбаатар хот, Монгол Улс  
Огноо: 2017 оны 12 дугаар сарын 8



ПЕТР МАРКИ  
Захирал

	Тодруулга	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 10 сарын 31 мян.төг (Аудитлаг- даагүй)
Хүү болон түүнтэй адилтгах орлого	5	469,100	1,956
Хүүний зардал	5	(34,078)	-
<b>Хүүний цэвэр орлого</b>		<b>435,022</b>	<b>1,956</b>
Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал	10	(11,590)	-
<b>Үйл ажиллагааны цэвэр орлого</b>		<b>423,432</b>	<b>1,956</b>
Удирдлагын болон үйл ажиллагааны зардал	6	(486,558)	(1,109)
Бусад зардал		(8,346)	(10)
<b>Татварын өмнөх ашиг/(алдагдал)</b>		<b>(71,472)</b>	<b>837</b>
Орлогын албан татварын зардал	7	(1,343)	(119)
<b>Тайлант хугацааны цэвэр ашиг/(алдагдал) буюу Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох нийт дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)</b>		<b>(72,815)</b>	<b>718</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг/(алдагдал) (төгрөгөөр)</b>			
Нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрсэн ашиг/ (алдагдал) (төгрөгөөр)	8	(0.73)	0.02

	Тодруулга	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 12 сарын 31 мян.төг (Дахин тайлагнасан*)
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>			
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	9	320,043	507,939
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	10	2,110,270	124,160
Урьдчилж төлсөн орлогын албан татвар		240	-
Бусад хөрөнгө	13	44,521	14,700
		<u>2,475,074</u>	<u>646,799</u>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>			
Биет бус хөрөнгө	11	270,210	295,000
Үндсэн хөрөнгө	12	64,337	23,073
		<u>334,547</u>	<u>318,073</u>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>			
		<u><b>2,809,621</b></u>	<u><b>964,872</b></u>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>			
Хаалттай бондын өглөг	14	300,200	-
Бусад сан	15	15,805	-
Бусад өр төлбөр	15	71,813	170,092
Орлогын албан татварын өглөг		-	162
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>			
		<u><b>387,818</b></u>	<u><b>170,254</b></u>
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>			
Хувьцаат капитал	16	2,500,000	800,000
Хуримтлагдсан алдагдал		(78,197)	(5,382)
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ</b>			
		<u><b>2,421,803</b></u>	<u><b>794,618</b></u>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ</b>			
		<u><b>2,809,621</b></u>	<u><b>964,872</b></u>

\* Энд үзүүлсэн тодорхой дүнгүүд нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн байдлын тайлантай холбоогүй бөгөөд Тодруулга 22-д толилуулсан дахин тайлагналуудыг оруулсан болно.

**ЛэндМН ББСБ ХХК**

**2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон 10 сарын хугацааны**

**Өмчийн Өөрчлөлтийн Тайлан**

	Тодруулга	Хувьцаат Капитал мян.төг	Хуримтлагдсан ашиг/(алдагдал) мян.төг	Нийт эздийн өмч мян.төг
<b>2016.01.01-ний өдрийн байдлаар</b>		400,000	2,082	402,082
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлого (аудитлагдаагүй)		-	718	718
<b>2016.10.31-ний өдрийн байдлаар (аудитлагдаагүй)</b>		<b>400,000</b>	<b>2,800</b>	<b>402,800</b>
<b>2017.01.01-ний өдрийн байдлаар</b>		<b>800,000</b>	<b>(5,382)</b>	<b>794,618</b>
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй алдагдал		-	(72,815)	(72,815)
Нэмж гаргасан энгийн хувьцаа	16	1,700,000	-	1,700,000
<b>2017.10.31-ний өдрийн байдлаар</b>		<b>2,500,000</b>	<b>(78,197)</b>	<b>2,421,803</b>

**ЛэндМН ББСБ ХХК**

**2017 оны 10 дугаар сарын 31-р дуусгавар болсон 10 сарын хугацааны  
Мөнгөн Гүйлгээний Тайлан**

	Тодруулга	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 10 сарын 31 мян.төг (Аудитлаг- даагүй)
<b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Татварын өмнөх ашиг/(алдагдал)		(71,472)	837
Тохируулга:			
Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал	10	11,590	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл	6	8,317	403
Биет бус хөрөнгийн хорогдуулга	6	24,790	-
Хуримтлагдсан хүү		200	-
Бусад сангийн өөрчлөлт		15,805	-
<b>Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг/(алдагдал)</b>		<b>(10,770)</b>	<b>1,240</b>
<i>Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрүүдийн өөрчлөлтүүд:</i>			
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны цэвэр өсөлт		(1,997,700)	(3,000)
Бусад хөрөнгийн цэвэр өсөлт		(29,821)	-
Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт		54,721	-
<b>Үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ</b>		<b>(1,983,570)</b>	<b>(3,000)</b>
Орлогын албан татварын төлөлт		(1,745)	-
<b>Үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(1,985,315)</b>	<b>(1,760)</b>
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ</b>			
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	12	(49,866)	(5,047)
Биет бус хөрөнгийн худалдан авалт		(153,000)	(147,000)
Үндсэн хөрөнгө худалдан борлуулсны орлого		285	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ</b>		<b>(202,581)</b>	<b>(152,047)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Нэмж гаргасан энгийн хувьцаанаас орсон мөнгө		1,700,000	-
Хаалттай бонд гаргаснаас орсон мөнгө*		645,000	-
Зээлээр авсан эх үүсвэр*		750,000	-
Хаалттай бондын эргэн төлөлт*		(345,000)	-
Зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт*		(750,000)	-
<b>Санхүүгийн үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>2,000,000</b>	<b>-</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр бууралт</b>		<b>(187,896)</b>	<b>(153,807)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9	507,939	400,034
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>9</b>	<b>320,043</b>	<b>246,227</b>
<b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ /Хүү/</b>			
Хүлээн авсан хүү		469,100	1,956
Төлсөн хүү		(34,078)	-

\* 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон 10 сарын хугацааны санхүүгийн үйл ажиллагааны хөдөлгөөнд хаалттай бондын хуримтлагдсан хүү 200 мянган төгрөгөөс өөр мөнгөн бус өөрчлөлт ороогүй.

## 1 Компанийн талаарх мэдээлэл

ЛэндМН ББСБ ХХК нь анх 2006 онд “Дуусашгүй Ундарга ХХК” нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 2015 оны 6 дугаар сард Санхүүгийн Зохицуулах Хорооноос (цаашид “СЗХ” гэх) зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаар компанийн нэр “Дуусашгүй Ундарга ББСБ ХХК” болж өөрчлөгдсөн. 2016 оны 12 сард тус компани нэрээ өөрсдийн үндсэн технологитой уялдуулан дахин өөрчилж, “ЛэндМН ББСБ ХХК” болгосон. “ЛэндМН ББСБ ХХК” нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. ЛэндМН ББСБ ХХК нь СЗХ-ноос 2015 оны 6 дугаар сарын 24-ны өдөр олгосон, 1/493 тоот, банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Уг тусгай зөвшөөрлөөр Монгол Улсад зээлийн үйл ажиллагаа явуулах эрхийг олгодог болно.

**Үндсэн үйл ажиллагаа.** Компани нь өөрийн шууд толгой компани болох Монгол Улсад үүсгэн байгуулагдсан Анд Системс ХХК-ийн хөгжүүлэн гаргасан ЛэндМН технологийг ашиглан, зээлийн үйлчилгээ огт/хангалттай хэмжээнд авч чаддаггүй хүмүүст гар утсанд суурилсан санхүүгийн үйлчилгээ буюу 24/7 цахим зээлийн үйлчилгээг үзүүлдэг. ЛэндМН технологи нь Анд Системс ХХК-ийн хөгжүүлэн гаргасан “финтек” шийдэл бүхий технологи бөгөөд технологийн лиценз нь Анд Системс ХХК-ийн өөр нэг охин компани болох Анд Системс Тек ХХК дээр бүртгэлтэй байдаг.

Компанийн шууд толгой компани нь Анд Системс ХХК бөгөөд эцсийн толгой компани нь Сингапур Улсад бүртгэлтэй, финтек гарааны компани болох Анд Глобал Пте.Лтд юм.

Компанийн албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 5-дугаар хороо, “Нью Майнд Групп”-ын байр.

Компанийн санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн. Тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянганы орноор, Монгол төгрөг (“Төг”)-өөр тайлагнасан.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого

**Тайлан бэлтгэх суурь ба нийцлийн мэдэгдэл.** Эдгээр санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс бэлтгэн гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын (үүнд СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (“НББОУС” болон тэдгээрийн тайлбарууд бүгд орно) дагуу, түүхэн өртгийн зарчим дээр үндэслэн бэлтгэгдсэн. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг дор толилуулав. Өөрөөр заагаагүй бол тус бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай мөрдсөн болно.

**Санхүүгийн хэрэглүүрүүд – Хэмжилтийн үндсэн нэр томъёо.** Санхүүгийн хэрэглүүрүүдийг ангиллаас нь хамааруулан бодит үнэ цэнэ эсвэл хорогдуулсан өртгөөр дор тайлбарласны дагуу бүртгэлд тусгадаг.

**Бодит үнэ цэнэ** нь ажил гүйлгээг бүртгэх өдөр зах зээлд оролцогчдын хооронд байнга хийгдэх арилжаагаар хөрөнгийг худалдах эсвэл өр төлбөрийг шилжүүлэх үнэ юм. Бодит үнэ цэнийг хамгийн сайн илэрхийлэх дүн нь идэвхитэй зах зээлийн арилжааны үнэ юм. Идэвхтэй зах зээл гэдэг нь хөрөнгө болон өр төлбөрийн хэлцлүүд нь үнийн мэдээллээр тогтмол хангахуйц түвшинд явагддаг зах зээлийг хэлнэ.

Идэвхтэй зах зээлд арилжаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тухайн хөрөнгө болон өр төлбөрийн заасан үнэ болон тухайн байгууллагын эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийг тоо ширхэгээр үржүүлэн гаргана. Тухайн компанийн эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн тоо ширхэг нь зах зээлийн ердийн өдөр тутмын арилжааны тоо ширхэгээс их бөгөөд позицийг нэг арилжаагаар зарах захиалга өгснөөр зах зээлийн заасан үнэнд нөлөөлөх нөхцөл байдал үүсгэх байсан ч, энэ аргыг үүнийг ашиглах боломжтой.

## **2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

Зах зээлийн мэдээлэл хомс бүхий зарим санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд, тэдгээрийн бодит үнэ цэнийг дискаунтилагдсан мөнгөн урсгалын аргаар эсвэл санхүүжигч талын санхүүгийн мэдээлэл зэргийг үндэслэн тооцоолно. Мөн зах зээл дээрх, харилцан хамааралгүй этгүүдийн хооронд саяхан хийгдсэн ажил гүйлгээний үнийг баримтлана.

Бодит үнэ цэнийг дотор нь түвшингээр нь ангилан тодорхойлох ба эдгээр түвшинг дараах байдлаар тодорхойлно. Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 1-р түвшин, тухайн хөрөнгө болон өр төлбөртэй холбоотой шууд (үнэ) болон шууд бус (үнийг ашиглан) боломжит өгөгдлүүдийг ашиглан, үнэлгээний аргуудаар бодит үнэ цэнийг тооцоолон гаргасан бол 2-р түвшин, зах зээл дээрх бэлэн өгөгдлүүд дээр бус зах зээл дээр мэдэгдэхгүй байгаа өгөгдлүүдийг илүү тулгаарлан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 3-р түвшингийн бодит үнэ цэнэ гэж тус тус ангилна.

*Өртөг* гэдэг нь хөрөнгийг худалдан авах үед мөнгөөр төлсөн болон бусад хэлбэрээр төлсөн төлбөрийн бодит үнэ цэнэ бөгөөд үүнд хөрөнгө худалдан авахтай холбоотой гарсан ажил гүйлгээний зардлууд ч мөн багтана. Бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй эсвэл хөрөнгийн зах зээлээс үнийг нь тодорхойлох боломжгүй, өмчөөрх хөрөнгө оруулалт болон дээрхтэй адил өмчийн хэрэглүүрээр арилжаалагдах үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг өртгөөр нь хэмжинэ.

*Гүйлгээний зардлууд* нь санхүүгийн хэрэглүүрүүдийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал гэдэг нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх байсан зардал юм. Гүйлгээний зардалд агент, борлуулагч агентын үүрэг гүйцэтгэж буй ажиллагсад, зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах агентлаг болон хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөрүүд, мөн шилжүүлэлтэнд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт буюу нэмэгдэл, санхүүжилтийн зардлууд, дотоод удирдлагын буюу хадгалалтын зардлууд орохгүй.

*Хорогдуулсан өртөг* нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс үндсэн дүнгийн аливаа эргэн төлөлтийг хасан, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлуулсан гүйлгээний зардал, мөн үнийн аливаа нэмэгдэл эсвэл хөнгөлөлтийн дүнгийн, үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт орно. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн хорогдуулсан нэмэгдэл буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй бөгөөд тэдгээрийг санхүүгийн байдлын тайлан дахь холбогдох зүйлийн дансны үнэд оруулан тусгасан болно.

*Үр ашигт хүүгийн арга* нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид дансны үнээс тооцогдох хүүгийн хувийг тогтмол байлгахгаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид дискаунтлаж санхүүгийн хэрэглүүрүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүгийн хувь болно. Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрийн мөнгөн урсгалыг хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл дискаунтлах боловч хэрэглүүрт тусгагдсан хөвөх хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг, мөн зах зээлийн түвшинд тохируулагддаггүй бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Тийм нэмэгдэл, хөнгөлөлтийг хэрэглүүрийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулна. Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд өгч авалцах бүх хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

**Санхүүгийн хөрөнгийн ангилал.** Санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. (а) зээл болон авлага; (б) худалдан борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө; (в) дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө болон (г) бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, үр дүнгийн тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, үр дүнгийн тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгийг дотор нь 2 ангилдаг: (i) анх хүлээн зөвшөөрөх үед ийнхүү ангилагдсан, ба (ii) худалдан борлуулах зорилгоор эзэмшихээр болсон. Компанийн 2016 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн хөрөнгө нь бүгд “зээл болон авлага” хэмээн ангилагдсан болно.

**Зээл болон авлагад** Компани ойрын ирээдүйд худалдах төлөвлөгөөгүй бөгөөд тогтмол, тодорхойлж болохуйц төлбөртэй, деривативын бус, хөрөнгийн зах зээлд бүртгэлгүй бүх санхүүгийн хөрөнгийг хамруулдаг. Компанийн 2016 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд дараах зүйлсийг СТОУС-н хэмжилтийн шаардлагын үүднээс “зээл болон авлага” хэмээн ангилсан болно: Үүнд Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө ба Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа.

**Санхүүгийн өр төлбөрийн ангилал.** Компанийн бүх санхүүгийн өр төлбөрүүд нь бусад санхүүгийн өр төлбөрөөр хэмжин ангилах ба бүгд хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

**Санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрөх.** Бүх санхүүгийн хэрэглүүрүүд нь анх бодит үнэ цэнэ дээр ажил гүйлгээний өртгийг нэмсэн дүнгээр бүртгэгддэг. Анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийн хамгийн найдвартай нотолгоо нь тухайн ажил гүйлгээний үнэ байдаг. Бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний үнийн хооронд зөрүү үүссэн нөхцөлд л, тухайн зөрүү дүнгээр анхдагч хүлээн зөвшөөрөлтийн олз, гарзыг бүртгэдэг бөгөөд энэхүү бодит үнэ цэнэ нь ижил төрлийн хэрэглүүрийн саяхан арилжаалагдсан дүн болох нь эсвэл зөвхөн зах зээл дээрээс бэлэн олж болохуйц мэдээлэл дээр үндэслэж, үнэлгээний аргачлалаар тооцсон болох нь нотлогдсон байх ёстой.

Зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон (“энгийн” худалдаа болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан хүлээлгэн өгөх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л худалдаа, худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу Компани санхүүгийн хөрөнгийг хүлээлгэн өгөх үүрэг хүлээсэн өдрөөр тухайн санхүүгийн хэрэгслийг хүлээн зөвшөөрнө. Бусад бүх худалдан авалтыг компани санхүүгийн хэрэгслийн гэрээний тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах.** Компани санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг хүлээн авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) Компани хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл шаардлага хангасан, дамжуулан өгөх хэлцэлд оролцсоны үр дүнд (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь шилжүүлээгүй мөн авч үлдээгүй боловч хяналтын эрхийг хадгалж үлдээгүй тохиолдолд. Нөгөө тал нь хөрөнгийг бүхэлд нь гуравдагч этгээдэд ямар нэгэн хязгаарлалтгүйгээр борлуулах бодит боломжгүй байгаа нөхцөлд хяналтыг авч үлдсэнд тооцно.

**Санхүүгийн өр төлбөрийг данснаас хасах.** Санхүүгийн өр төлбөрийн төлөх үүргийн хугацаа дууссан, санхүүгийн өр төлбөр төлөх үүргээс чөлөөлөгдсөн болон уг өр төлбөрийг төлөх үүрэг дуусгавар болсон үед санхүүгийн өр төлбөрийг данснаас хасна. Санхүүгийн өр төлбөрийн хугацаа дуусаагүй үед тухайн өр төлбөрийн нөхцөл ихээхэн өөрчлөгдсөн үед, эсвэл зээлдүүлэгчээс хуучин өр төлбөрийнхөө оронд өөр нөхцөлтэй, шинэ өр төлбөр сольж хүлээж авсан тохиолдолд, өмнөх өр төлбөрийг данснаас хасч, шинэ өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх бөгөөд шинэ болон хуучин болон шинэ өр төлбөрийн дансны үнийн зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

**Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт.** Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа бий болсон, хөрөнгийн эсвэл бүлэг хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгалын дүн болон цаг хугацаанд найдвартайгаар тооцоолж болохуйц нөлөө үзүүлэх, нэг буюу хэд хэдэн үйл явдал үүссэн тухайн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Хэрэв Компани санхүүгийн хөрөнгийг тусад нь үнэлэхэд үнэ цэнийн бууралт болсныг харуулах бодит нотолгоо байхгүй болохыг тодорхойлсон бол тухайн хөрөнгийг зээлийн эрсдлийн ижил төрлийн шинж чанартай санхүүгийн хөрөнгийн бүлэгт багтаан хамтатган үнэлдэг. Үнэ цэнийн бууралтыг илтгэх шинж байгаа эсэхийг үнэлэхдээ Компанийн харгалзан үзэх үндсэн хүчин зүйл нь эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн эсэх юм.

Түүнчлэн, үнэ цэнийн бууралт үүссэн эсэхийг илэрхийлэх бодит нотолгоо байгаа эсэхийг тодорхойлохдоо дараах үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ:

- Хуваарьт төлбөрийн аль нэг нь хугацаа хэтэрсэн бөгөөд хугацаа хэтрэлт нь төлбөр тооцооны системээс үүссэн сааталтай холбоогүй;
- Компанийн олж авсан мэдээллээр зээлдэгч нь санхүүгийн мэдэгдэхүйц хүндрэлд орсон нь баталгаажсан; эсвэл
- улсын буюу орон нутгийн эдийн засгийн нөхцөл байдал зээлдэгчид нөлөөлөхүйцээр өөрчлөгдсөнөөс зээлдэгчийн төлбөр төлөлтийн байдал муудсан.

Тодруулга 10-д толилуулснаар харилцагчдад олгосон зээлүүд нь богино (1 сар хүртэл) хугацаатай бөгөөд тайлагналын өдрөөс энэхүү санхүүгийн тайлангууд батлагдахаас өмнөх өдөр хүртэлх хугацаанд хугацаа хэтрээгүй эсвэл маш бага хугацаа хэтрэлттэй байсан. Тиймээс тусгайлсан үнэлгээгээр үнэ цэнийн бууралтын нөөцийг бүртгэх нөхцөл байдал үүсээгүй юм. Иймд харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралтыг хамтатган үнэлэх аргачлал дээр үндэслэж хийдэг.

Хэрэв хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан бөгөөд түүний гэрээний нөхцлийг өөрчлөн тохиролцсон эсвэл нөхцлүүдийг зээлдэгч эсвэл үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал муудсаны улмаас өөрчилсөн тохиолдолд үнэ цэнийн бууралтыг нөхцөл байдал өөрчлөгдөхийн өмнөх үр ашигт хүүг ашиглан тооцно.

Үнэ цэнийн бууралтын алдагдлыг нөөцийн сангийн дансанд бүртгэж, хөрөнгийн дансны үнийг хүлээгдэж буй мөнгөн урсгалын (зээлийн ирээдүйн хэрэгжээгүй алдагдлыг оруулаагүй дүнгээр) анхны үр ашигт хүүгээр тооцсон өнөөгийн үнэ цэнэ хүртэл бууруулж бүртгэнэ.

Хэрэв үнэ цэнийн бууралтын алдагдлын дүн дараагийн тайлант үеүдэд буурсан бөгөөд алдагдлын уг бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш тохиосон бодит үйл явдалтай холбох боломжтой бол өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдлыг тайлант хугацааны үнэ цэнэ бууралтын сангийн дансаар буцаана.

Хөрөнгийг нөхөн төлүүлэх бүхий л шаардлагатай арга хэмжээг авсан бөгөөд алдагдлын дүнг тодорхой болгосны дараа найдваргүй болсон авлагыг үнэ цэнийн бууралтын санг ашиглан данснаас хасна. Өмнө нь найдваргүй гэж тодорхойлогдон данснаас хасагдсан авлага эргэн төлөгдсөн тохиолдолд эргэн төлөгдсөн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтын алдагдлын дансны кредитэд бичнэ.

**Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө.** Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд кассан дахь бэлэн мөнгө, банкинд байршуулсан хугацаагүй хадгаламжууд, мөн банкуудад 3-аас доош сарын хугацаатай байршуулсан, өндөр хөрвөх чадвар бүхий мөнгөн хөрөнгүүд орно. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Хязгаарлалт бүхий балансууд нь мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд тусгагддаггүй.

**Үйл ажиллагааны түрээс.** Компани нь түрээсийн гэрээнд түрээслэгчээр оролцож, өмчлөлийн ихэнхи эрсдэл болон өгөөж нь түрээслүүлэгчээс Компанид шилжин ирээгүй тохиолдолд түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан хуваарилж, тухайн тайлант хугацааны орлого, үр дүнгийн тайланд (түрээсийн зардлаар) бүртгэнэ.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Хэрэв хөрөнгийг үйл ажиллагааны түрээсээр түрээслүүлсэн тохиолдолд түрээсийн авлагыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хуваарилан түрээсийн орлогоор бүртгэнэ.

**Үндсэн хөрөнгө.** Компанийн эзэмшиж буй үндсэн хөрөнгүүдийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хассан дүнгээр тусгана. Урсгал засвар, үйлчилгээний өртгийг гарсан үед нь зардлаар бүртгэнэ. Үл хөдлөх хөрөнгө болон тоног төхөөрөмжийн томоохон бүрэлдэхүүн хэсгийг шинэчлэсэн бол, холбогдох өртгийг капиталжуулж, хуучин сольсон хэсгийн дансны үнийг зарлагадана.

Тайлант хугацааны эцэст удирдлага үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсныг илтгэх аливаа үзүүлэлт байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв ийм үзүүлэлт байгаа нөхцөлд хөрөнгийн нөхөгдөх үнийг тооцоолох ба энэ хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндрөөр тодорхойлогддог. Дансны үнийг нөхөгдөх өртөг хүртэл бууруулан үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн жилийн орлого, үр дүнгийн тайланд бүртгэдэг. Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ эсвэл бодит үнэ цэнээс борлуулалтын өртгийг хассан тооцоолол өөрчлөгдсөн нөхцөлд өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцааж болно.

Хөрөнгө борлуулсны олз, гарзыг тодорхойлохдоо борлуулалтаас олсон орлогыг дансны дүнтэй харьцуулан тооцож, тухайн жилийн орлого, үр дүнгийн тайланд бүртгэнэ (үйл ажиллагааны бус орлого, зардал хэсэгт).

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тэдгээрийн өртгийг доорх хүлээгдэж буй ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь бууруулан хуваарилж тооцно:

### Ашиглагдах хугацаа, жилээр

Тавилга, эд хогшил, оффисын тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютер ба техник тоног төхөөрөмж	3 жил

Хөрөнгийн үлдэх өртөг гэдэг нь хөрөнгө хуучирсан, ашиглагдах хугацаа нь дуусч буй гэж үзвэл Компани хөрөнгийг борлуулснаас олох боломжтой үнээс борлуулалтын зардлыг хассан дүнг хэлнэ. Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглагдах хугацааг тайлант үе бүрийн эцэст хянаж, шаардлагатай гэж үзвэл өөрчилнө.

**Биет бус хөрөнгө.** Гүүдвилээс бусад биет бус хөрөнгө нь ашиглах тодорхой хугацаатай бөгөөд Компанийн үндсэн биет бус хөрөнгө нь лиценз юм.

Худалдан авсан компьютерийн программ хангамжийн лицензүүдийг өртөг дээр тэдгээрийг ашиглахад бэлэн болгохтой холбогдон гарсан зардлыг нэмсэн дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгүүдийг тэдгээрийн ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулна:

### Ашиглагдах хугацаа, жилээр

ЛэндМН технологийн лиценз	10 жил
---------------------------	--------

Үнэ цэнэ нь буурсан бол биет бус хөрөнгийн дансны үнийг хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ болон түүний бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнгийн аль их дүн хүртэл бууруулна.

**Орлогын албан татвар.** Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр хэрэглэгдэж байсан, хэрэгжих нь тодорхой болсон хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн жилийн болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл шууд өмчид бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрөгдөнө.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Тайлант хугацааны татвар нь тухайн болон өмнөх хугацаанд үүссэн татвар ногдох ашиг, алдагдалтай холбоотой татварын байгууллагад төлөх эсвэл түүнээс нөхөн авах дүн болно. Санхүүгийн тайланг холбогдох татварын албанд тушаахаас өмнө баталгаажуулсан гэж тооцож татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилан тооцно. Орлогоос бусад зүйлд ногдуулсан албан татваруудыг үйл ажиллагааны зардал хэсэгт бүртгэдэг.

Хойшлогдсон орлогын татварыг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь болон санхүүгийн тайлагналын зорилгоор тооцогдсон бүртгэлийн үнийн түр зөрүүн дээр хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын өглөгийг бүх татварт тооцогдох түр зөрүүн дээр хүлээн зөвшөөрнө. Татвар тооцогдох түр зөрүү болон татварын алдагдлыг шилжүүлэх зорилгоор хойшлогдсон татварын хөрөнгүүд нь татвар тооцогдож болох татварын ирээдүйн орлогын боломжит хэмжээгээр бүртгэгдэнэ.

**Татварын тодорхой бус байр суурь.** Компанийн татварын тодорхой бус нөхцөл байдлын талаар удирдлага тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж үзнэ. Татварын албанаас авч хэлэлцэж байгаа татварын тодорхой бус нөхцөл байгаа үед удирдлага татварын өглөгийн дүнг тодорхойлохдоо нэмэлт татварын ногдуулалт үүсэх нөхцөлийг илүүд тооцож бүртгэдэг. Үнэлгээ нь тайлант үеийн эцэст хэрэглэгдэж байсан, үндсэндээ хэрэгжих нь тодорхой болсон хууль тогтоомжийн тайлбар эсвэл шүүх болон тухайн асуудлын талаарх бусад зохицуулалтыг үндэслэн хийгддэг. Тайлант хугацааны эцэст орлогоос бусад зүйлс дээр төлөх төлбөр торгууль, алданги хүү, татвар хураамжтай холбоотой өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхдөө түүнийг барагдуулахад гарах зарцуулалтын талаар удирдлагын хамгийн сайн үнэлгээнд үндэслэн тооцоолно. 2017 оны 10 дугаар сар 31 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр компанийн удирдлага татварын тодорхой бус байр суурьд зориулж сан байгуулах шаардлагагүй гэж үзсэн.

**Нэмэгдсэн өртгийн албан татвар.** Монгол Улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиар санхүүгийн үйлчилгээний үйл ажиллагаа нь (зээл олголт г.м) НӨАТ-с чөлөөлөгдсөн байдаг ба Компанийн удирдлага Компанид санхүүгийн бус үйлчилгээнээс үүдэлтэй НӨАТ-ын өр төлбөр байхгүй хэмээн дүгнэсэн болно. Тиймээс, 2017 оны 10 дугаар сарын 31 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар, компани нь НӨАТ төлөгчөөр бүртгүүлээгүй болно.

**Өр төлбөр болон зардлын сан.** Өр төлбөр болон зардлын сан нь төлөгдөх хугацаа болон хэмжээ нь тодорхой бус санхүүгийн бус өглөг юм. Компани урьд нь тохиосон үйл явдлын үр дүнд өнөөгийн эрх зүйн эсвэл үүсмэл үүрэг хүлээсэн бөгөөд уг үүргийг биелүүлэхэд эдийн засгийн үнэ цэнэ бүхий эх үүсвэрийг төлөх магадлалтай, мөн уг үүргийн дүнг баталгаатайгаар тооцоолох боломжтой тохиолдолд зардлын санг хуримтлуулан байгуулна.

**Бусад өглөг.** Бусад өглөгийг нөгөө тал гэрээнд заасан үүргээ биелүүлсэн үед хуримтлуулан тооцож хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

**Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт.** Хүүгийн орлого, зардлыг өрийн хэрэгсэл бүрийн хувьд аккруэл суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардалд бүртгэдэг.

Үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхэд шууд холбоотойгоор нэмэгдэн гардаг, жишээлбэл төлбөрийн чадварыг үнэлэх, зээлийн баталгаа эсвэл барьцааг үнэлэх болон бүртгэх, хэрэглүүрийн нөхцлүүдийг хэлцэх болон холбогдох баримт бичиг боловсруулах зэрэг гэрээ байгуулахтай холбоотой аливаа хураамжууд орно. ЛэндМН зээл олголт бүрт ногдуулах хураамжийн орлого нь хүүний орлого гэж нэрлэгдэхгүй боловч үр ашигт хүүний нэг хэсэг юм.

Зээл болон бусад өрийн хэрэгслүүдийн эргэн төлөгдөх магадлал бага болсон үед тэдгээрийг хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хүртэл бууруулж бүртгэх бөгөөд түүнээс хойш өнөөгийн үнэ цэнийн өсөлтийг тухайн хөрөнгийн үнэ цэнэ бууралтын алдагдлыг тооцоход ашигласан үр ашигт хүүгийн үндсэн дээр тооцоолж хүүгийн орлогоор бүртгэдэг.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлын зүйлүүдийг ерөнхийдөө аккруэл суурь дээр үндэслэн тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт тохирсон үйлчилгээнээс бодитоор үзүүлсэн байгаа үйлчилгээний хувь хэмжээгээр тооцдог.

**Хувьцаат капитал.** Энгийн хувьцааг эздийн өмч гэж ангилдаг. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой нэмэлт зардлыг хувьцаа борлуулсны татварын дараах орлогоос хасах дүнгээр эздийн өмчид тусгадаг.

**Гадаад валютын хөрвүүлэлт.** Компанийн үйл ажиллагааны валют нь түүний үйл ажиллагаагаа явуулж буй эдийн засгийн үндсэн орчны валют юм. Компанийн үйл ажиллагааны болон тайлагналын валют нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг юм.

Мөнгөн зүйлст тооцогдох хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцсийн өдрийн Монголбанкны албан ханшаар хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцсийн өдрийн Монголбанкны албан ханш руу хөрвүүлснээс үүсэх ханшийн олз, гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлүүдийг тайлант хугацааны хаалтын ханшаар хөрвүүлж бүртгэхгүй.

**Хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тусгах.** Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр бүртгэх нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийн хаалт хийх эрх зүйн үндэслэл байгаа бөгөөд төлбөрийг цэвэр дүнгээр хийх эсвэл хөрөнгийг худалдаж, нэгэн зэрэг өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө байгаа тохиолдолд л зөвшөөрөгдөнө.

**Ажиллагсадын зардал болон холбогдох шимтгэлүүд.** Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг Компанийн ажиллагсад холбогдох ажил үйлчилгээ үзүүлсэн жилд хүлээн зөвшөөрдөг. Цалинтай ээлжийн амралт болон нөхөн олговортой бусад богино хугацаат хуримтлагдах чөлөө авалтыг ажиллагсад ирээдүйд нөхөн олговортой чөлөө авах эрхийг үүсгэх үйлчилгээг болон цалинтай холбоотой бусад зардлуудыг Компанийн ажиллагсад чөлөө авалтыг (жишээ нь, өвчний улмаас чөлөө авалтыг) чөлөө авах үед тус тус хүлээн зөвшөөрдөг.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд хуулийн дагуу тэтгэврийн, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын сангуудад шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлүүдийг үүссэн үед нь орлого, үр дүнгийн тайланд зардлаар бүртгэдэг. Энд дурьдсан улсын тогтмол шимтгэлтэй сангуудад болон тогтмол шимтгэлтэй хөтөлбөрт төлдөг төлбөрүүдээс гадна Компани өөр ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмжийн төлбөр хийх хууль эрх зүйн буюу зохиомол үүрэг хүлээгээгүй болно.

**Нэгж хувьцаанд ногдох ашиг.** Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг (алдагдал)-г Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох ашиг буюу алдагдлыг тайлант хугацааны турш оролцоотой байсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хувааж гаргана. Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг (алдагдал)-г Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)-г (хувьцаанд хөрвөх давуу эрхтэй хувьцааны хүү эсвэл хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бондын хүүгийн татварын дараах зардлуудаар тохируулсан) тайлант хугацааны турш оролцоотой байсан жигнэсэн дундаж энгийн хувьцааны тоон дээр энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бүх хэрэгслүүдийг хөрвүүлэхэд нэмэгдэж үүсэх боломжит энгийн хувьцааны тоог нэмж гаргасан нийт энгийн хувьцааны тоонд хувааж гаргана.

**Сегментийн тайлагнал.** Үйл ажиллагааны сегментүүдийг компанийн үйл ажиллагааны гол шийдвэр гаргагчдад бэлтгэн өгдөг тайлан мэдээллийн дагуу санхүүгийн тайландаа тайлагнадаг. Нийт сегментүүдийн орлого, үр дүн болон хөрөнгийн 10 ба түүнээс дээш хувийг дангаараа бүрдүүлж буй сегментийг тусад нь тайлагнана.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

**Холбоотой талуудын ажил гүйлгээ.** Холбоотой талууд гэдэгт Компанитай дараах байдлаар холбогдсон аж ахуй нэгж болон хувь хүн орно. Үүнд:

- (а) Компанитай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:
- (i) Компанид дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
  - (ii) Компанид томоохон нөлөөлөлтэй эсвэл
  - (iii) Компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.
- (б) Дараах нөхцлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Компанид хамааралтай болно. Үүнд:
- (i) Аж ахуй нэгж болон Компани нь нэг ижил Группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
  - (ii) Нэг аж ахуй нэгж нь нөгөө аж ахуй нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуй нэгж нь гишүүн болох Компанийн хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
  - (iii) Аль аль аж ахуй нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
  - (iv) Нэг аж ахуй нэгж нь гуравдагч аж ахуй нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани.
  - (v) Аж ахуй нэгж нь Компанийн эсвэл Компанитай холбоотой аж ахуй нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Компани нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Компанитай холбоотой тал болно.
  - (vi) Аж ахуй нэгжийг (а)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
  - (vii) (а)(i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуй нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуй нэгжийн (эсвэл аж ахуй нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.
  - (viii) Аж ахуй нэгж нь эсвэл Компанийн аль нэг гишүүн нь Компани эсвэл Компанийн толгой компанид гол удирдах албан тушаалтай.

Холбоотой талуудын боломжит бүх хамаарлыг харгалзахдаа зөвхөн хуулийн хэлбэрийг биш хамаарлын мөн чанарыг чухалчлан анхаарсан болно.

Холбоотой талуудтай хийсэн бүх материаллаг ажил гүйлгээ болон үлдэгдлийг санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудад тодруулсан бөгөөд дэлгэрэнгүйг Тодруулга 20-с харна уу.

## 3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон Толилуулгад орсон өөрчлөлтүүд

Компани 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа доорх стандарт болон стандартын нэмэлт өөрчлөлтүүдээс бусад тохиолдолд өмнөх санхүүгийн жилд мөрдөж байсан бүртгэлийн бодлогуудаа энэ санхүүгийн жилд тууштай мөрдөж байгаа болно.

### Шинэ болон өөрчлөгдсөн стандарт болон стандартын тайлбарууд

- |                             |   |
|-----------------------------|---|
| • НББОУС 7 Нэмэлт өөрчлөлт  | <i>Мөнгөн гүйлгээний тайлан: Толилуулгын санаачилга</i>   |
| • НББОУС 12 Нэмэлт өөрчлөлт | <i>Орлогын албан татвар: Бодит бус алдагдалд хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрөх</i>  |
| • СТОУС 12 Нэмэлт өөрчлөлт  | <i>Бусад аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалтын толилуулга: 2014-2016 СТОУС-үүдэд жил бүр хийгддэг сайжруулалтуудад орсон, СТОУС 12-н хамрах хүрээний нэмэлт тайлбар</i> |
| • СТОУС 14                  | <i>Зохицуулах байгууллагатай холбоотой хойшлуулсан данс</i>   |

Дээрх шинэ стандарт болон стандартуудын нэмэлт өөрчлөлт нь Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлээгүй.

### 3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон Толилуулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

#### Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд

Шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн боловч хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хугацаа нь хараахан болоогүй байгаа Стандарт болон стандартуудын нэмэлт өөрчлөлтүүдийг доор жагсаасан бөгөөд Компани тэдгээрийг хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хугацаанаас нь эхлэн нягтлан бодох бүртгэлдээ мөрдөхөөр төлөвлөж байна:

- |   |  |
|---|--|
| • СТОУС 2 Нэмэлт өөрчлөлт                     | <i>Хувьцаанд суурилсан төлбөрийн ангилал болон хэмжилт<sup>1</sup></i>   |
| • СТОУС 4 Нэмэлт өөрчлөлт                     | <i>СТОУС 4 Даатгалын гэрээтэй санхүүгийн хэрэглүүр<sup>1</sup></i>   |
| • НББОУС 40 Нэмэлт өөрчлөлт                   | <i>ХОЗҮХХ-н шилжүүлэг<sup>1</sup></i>  |
| • СТОУС 10 болон НББОУС 28 Нэмэлт өөрчлөлт    | <i>Хөрөнгө оруулагч болон Хараат компани/Хамтарсан үйлдвэрийн хоорондох хөрөнгийн борлуулалт болон хөрөнгөөрх хөрөнгө оруулалт<sup>4</sup></i> |
| • СТОУС 9                                     | <i>Санхүүгийн хэрэглүүр<sup>1</sup></i>  |
| • СТОУС 15                                    | <i>Харилцагчтай байгуулсан гэрээний орлого<sup>1</sup></i>   |
| • СТОУС 16                                    | <i>Түрээс<sup>2</sup></i>  |
| • СТОУС 17                                    | <i>Даатгалын гэрээ<sup>3</sup></i>   |
| • СТОУСТХ 22                                  | <i>Гадаад валютаарх ажил гүйлгээ болон Урьдчилж төлсөн төлбөр<sup>1</sup></i>  |
| • СТОУСТХ 23                                  | <i>Орлогын албан татварын тодорхой бус асуудлууд<sup>2</sup></i>   |
| • 2014-2016 жилийн СТОУС-н ээлжит сайжруулалт | <i>СТОУС-уудын 2016 оны 12 дугаар сард хэвлэн гаргасан нэмэлт сайжруулалтууд<sup>1</sup></i>   |

<sup>1</sup> 2018 оны 1 дүгээр сарын 1 ба түүнээс хойш эхлэх тайлант хугацаанаас эхэлж мөрдөгдөнө

<sup>2</sup> 2018 оны 1 дүгээр сарын 1 ба түүнээс хойш эхлэх тайлант хугацаанаас эхэлж мөрдөгдөнө

<sup>3</sup> 2021 оны 1 дүгээр сарын 1 ба түүнээс хойш эхлэх тайлант хугацаанаас эхэлж мөрдөгдөнө

<sup>4</sup> Хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хугацаа нь хараахан тодорхой болоогүй. Аж ахуйн нэгжүүд хугацаанаас нь өмнө мөрдөж болно.

Компанийн санхүүгийн тайланд хамааралтай байж болох СТОУС-уудын талаарх нэмэлт мэдээллүүд:

#### (а) Санхүүгийн Хэрэглүүрүүд

СТОУС-н Зөвлөл 2014 оны 9 сард СТОУС 9-н сүүлийн хувилбарыг хэлэлцэн баталсан. Энэхүү стандарт нь санхүүгийн хэрэглүүрийн ангилал болон хэмжилт, үнэ цэнийн бууралт, болон хэйджийн бүртгэлийг шинэчлэсэн. Компани СТОУС 9-г 2018 оны 1-р сарын 1-с мөрдөж эхэлнэ. СТОУС 9-г мөрдсөнөөр санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллүүдийг доор хураангуйлан харуулав:

#### (i) Ангилал ба хэмжилт

Компани нь СТОУС 9 –г мөрдсөнөөр санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал болон хэмжилтэнд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна. Тухайлбал, гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах зорилго бүхий бизнесийн загварт багтах өрийн хэрэглүүрүүдийг, хэрэв тус өрийн хэрэглүүрүүдийн мөнгөн гүйлгээ нь гол төлөв үндсэн ба хүүгийн төлбөрөөс бүрдэж байвал, хүлээн зөвшөөрсөн үеэс эхлэн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

#### (ii) Үнэ цэнийн бууралт

СТОУС 9-ийн шаардлагаар СТОУС 9-ийн дагуу бодит үнэ цэнэ нь орлого, үр дүнгийн тайланд бүртгэгддэггүй түрээсийн авлага, зээлийн үүрэг болон санхүүгийн баталгааны гэрээ, хорогдуулсан өртөг эсвэл бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгддэг зээлийн хэрэгсэлд байгуулах үнэ цэнийн бууралтын алдагдлыг ирээдүйн 12 сараар эсвэл ашиглалтын хугацаагаар хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвар дээр үндэслэн бүртгэнэ. Хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварын хэрэглээ нь үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөх хэмжээг ихэсгэх ба учир нь НББОУС 39-ийн дагуу үнэ цэнийн бууралтыг зөвхөн бодит нотолгоон дээр үндэслэн тооцохтой харьцуулахад уг загвар нь санхүүгийн хөрөнгийг анх бүртгэхдээ ирээдүйн 12 сард хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү байдлаар үнэ цэнийн бууралтын алдагдлын санг байгуулдаг.

### 3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон Толилуулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

Гүйцэтгэх удирдлага СТОУС 9-ийг нэвтрүүлснээр ирээдүйд компанийн санхүүгийн үзүүлэлт, санхүүгийн хөрөнгийн хүрээнд тайлагнах дүнгүүдэд нөлөөлж, СТОУС 9-ийн дагуу хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвараар зээлийн эрсдлийн алдагдлын сан урьдчилан байгуулахаар төлөвлөж байна. Компани уг стандартыг нэвтрүүлэхдээ санхүүгийн хэрэглүүрт хүлээгдэж буй зээлийн алдагдлын ойролцоолсон тооцоололд илүү нарийн дүн шинжилгээ хийн, ирээдүйн хүчин зүйлсийг багтаан бүх холбогдох мэдээлэлийг ашиглан гүйцэтгэнэ.

#### (б) Харилцагчтай байгуулсан гэрээний орлого

СТОУС 15 нь харилцагчидтай хийсэн гэрээнээс үүдэлтэй орлогыг тооцох шинэ таван алхам бүхий загварыг бий болгосон. СТОУС 15-ын дагуу орлогыг бараа бүтээгдэхүүн борлуулсан эсвэл үйлчилгээг үзүүлсний үр дүнд Компанийн хүлээж авахаар хүлээгдэж буй төлбөрийг тусгасан дүнгээр хүлээн зөвшөөрнө. СТОУС 15-ын зарчмууд нь орлогыг хэмжих, хүлээн зөвшөөрөх илүү зохион байгуулалттай арга барилаар хангасан. Тус стандарт нь нийт орлогын задаргааг, гүйцэтгэлийн үүргийн тухай мэдээлэл, гэрээний хөрөнгө ба өр төлбөрийн дансны үлдэгдлийн өөрчлөлт болон гол үнэлэмж ба тооцооллуудыг санхүүгийн тайланд толилуулах тоон болон чанарын шаардлагуудыг багтаасан. Уг стандарт нь СТОУС-ын дагуу одоогийн байдлаар мөрдөгдөж буй бүх орлого хүлээн зөвшөөрөх шаардлагыг орлоно. Компани СТОУС 15-г 2018 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Компанийн удирдлага нь СТОУС 15-г мөрдсөнөөр санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

#### (в) Валютын ханшийг тодорхойлох ажил гүйлгээний огноо

СТОУТХ-тайлбар 22 нь гадаад валютаар төлсөн буюу хүлээн авсан урьдчилгаа төлбөрийн валютын ханшийг тодорхойлох зорилгоор ажил гүйлгээ гарсан өдрийг тодорхойлно. Тайлбар нь 2018 оны 1 дүгээр сарын 1-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө. Компани 2018 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тус тайлбарыг мөрдсөнөөр санхүүгийн байдал болон санхүүгийн үйл ажиллагаанд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

#### (г) Орлогын татварын зардал

СТОУТХ-тайлбар 23 нь орлогын татварын бүртгэлийн эргэлзээний нөлөөг хэрхэн шийдвэрлэхийг тусгасан НББОУС12 Орлогын татварт тавигдах шаардлагыг дэмждэг. Тус тайлбар нь 2019 оны 1 дүгээр сарын 1-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө. Компани 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тус тайлбарыг мөрдсөнөөр санхүүгийн байдал болон санхүүгийн үйл ажиллагаанд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

#### 4 Нягтлан бодох бүртгэлийн гол тооцооллууд болон үнэлэмжүүд

Компани нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд болон дараагийн тайлант хугацааны хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд нөлөөлөх таамаглал болон тооцоолол хийдэг. Тооцоолол болон үнэлэмжүүдийг тасралтгүй хянаж, дахин үнэлдэг бөгөөд энэ нь удирдлагын туршлага болон нөхцөл байдалд зохистой гэж үзсэн ирээдүйн үйл явцын талаарх хүлээлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлүүд дээр суурилдаг. Удирдлага нь тооцооллоос гадна, нягтлан бодох бүртгэлийн бодлогоо хэрэгжүүлэх явцад өөрсдийн үнэлэмжийг хийх шаардлагатай болдог. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнд хамгийн ихээр нөлөөлөх үнэлэмжүүд болон дараагийн тайлант хугацааны хөрөнгө, өр төлбөрийн дансны дүнд ихээхэн нөлөө үзүүлэх тооцооллуудыг нэгтгэн толилуулж байна:

**Зээл болон авлагын үнэ цэнийн бууралтын алдагдал.** Компани гаргасан зээлүүдийн үнэ цэнэ нь буурсан эсэхийг бүлгээр нь тогтмол шалгадаг. Компани тайлант хугацаанд үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэхийг тогтоохдоо зээл бүрийг тус тусад нь авч үзэхээсээ өмнө, эхлээд бүлгээр нь авч үзэн, уг бүлгийн ирээдүйн мөнгөн урсгал нь хэмжигдэхүйц хэмжээнд буурсныг илтгэх мэдээлэл байгаа эсэх дээр үнэлгээ хийнэ. Үнэ цэнийн бууралтыг илтгэх мэдээлэлд зээлдэгчийн эргэн төлөлтийн байдалд сөрөг өөрчлөлт гарсан, эсвэл улс орны эдийн засгийн өөрчлөлт нь зээлийн авлагууд эргэн төлөгдөхгүй байгаатай шууд холбоотой гэх мэт мэдээллүүд багтана.

Удирдлага нь хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгалын төлвийг ижил төрлийн зээлийн эрсдлийн шинж чанартай хөрөнгүүдийн түүхэн алдагдлын мэдээлэл болон ижил төрлийн хөрөнгүүдийн үнэ цэнийг бууралтыг илтгэх бодит нөхцөл байдлууд дээр үндэслэн тооцоолон гаргана. Ирээдүйн мөнгөн урсгалын дүн болон цаг хугацааг тооцоолон гаргахад ашигласан арга болон тооцооллуудыг тогтмол хугацаанд эргэн хянаж, тооцоолсон дүн болон бодит алдагдлын дүнгийн зөрүүг аль болох багасгыг зорьдог.

Бодит алдагдлын дүн нь тооцоолсон алдагдлын дүнгээс 20%-р их эсвэл бага гарах тохиолдолд, зээлийн авлагын үнэ цэнийн бууралтын алдагдлын дүнг 2,318 мянган төгрөгөөр (2016: 0) ихэсгэх эсвэл багасгах болно. Дангаараа том үнийн дүнтэй зээлийн авлагуудын үнэ цэнийн бууралтын алдагдлын тооцоолол нь тухайн зээлийн эргэн төлөгдөх дүнг харгалзан үзсэн, ирээдүйн мөнгөн урсгалын дискаунтчилагдсан дүн дээр суурилна.

**Биет бус хөрөнгө.** Компанийн биет бус хөрөнгө нь Монгол улсын нутаг дэвсгэрт зээлийн үйл ажиллагаа явуулах тусгай эрх бүхий 50 жилийн хугацаатай ЛэндМН системийн лицензээс бүрдэнэ. Удирдлага лицензийг ашиглахаар хүлээж буй хамгийн сайн тооцоололдоо үндэслэн лицензийн ашиглалтын хугацааг 10 жил байна гэж тооцоолсон. Хүлээгдэж буй ашиглах хугацаа болон технологийн дэвшлийн өөрчлөлт нь лицензийн ашиглалтын хугацаанд нөлөөлж болох ба ирээдүйд хорогдуулгын хугацаанд өөрчлөлт хийхэд хүргэж болзошгүй юм.

#### 5 Хүү болон түүнтэй адилтгах цэвэр орлого ба Сегментийн мэдээлэл

2017 болон 2016 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацаанд Компани бизнесийн нэг сегментэд үйл ажиллагаа явуулсан бөгөөд энэ нь Монгол улсын нутаг дэвсгэрт иргэдэд шуурхай зээлийн үйлчилгээ үзүүлэх юм. Компанийн гол шийдвэр гаргагчдад мэдээллэсэн мэдээлэл нь Компанийн нөөцийг нэгтгэсэн мөн үйл ажиллагааны сегментийн санхүүгийн мэдээлэл байхгүй тул нөөцийн хуваарилалт ба гүйцэтгэлийн үнэлгээний зорилгоор Компанийн үйл ажиллагааны үр дүнг бүхэлд нь авч үздэг. Тиймээс, үйл ажиллагааны сегменттэй холбоотой мэдээлэл тусгагдаагүй болно. Компанийн үндсэн үйл ажиллагаа болон үйлчлүүлэгчид нь Монгол улсын нутаг дэвсгэрт байршсан тул газар зүйн сегментийн мэдээлэл мөн тусгагдаагүй болно. 2017 болон 2016 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацаанд Компанийн орлогын 10 ба түүнээс дээш хувийг дангаараа бүрдүүлсэн харилцагч байгаагүй.

**5 Хүү болон түүнтэй адилтгах цэвэр орлого ба Сегментийн мэдээлэл (үргэлжлэл)**

	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 10 сарын 31 мян.төг (аудитлаг- даагүй)
<b>Хүүгийн орлого</b>		
Банкинд байршуулсан харилцах, хадгаламж	13,431	1,941
Бусад хүүгийн орлого	1,645	-
<b>ЛэндМН шимтгэлийн орлого</b>		
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа - ЛэндМН систем	454,024	15
<b>Нийт хүү болон түүнтэй адилтгах цэвэр орлого</b>	<b>469,100</b>	<b>1,956</b>
<b>Хүүгийн зардал</b>		
Хаалттай бонд болон зээлийн хүү	(34,078)	-

ЛэндМН шимтгэлийн орлого нь ЛэндМН системээр олгогдож байгаа зээлийн нэг удаагийн шимтгэлийн орлогыг илэрхийлдэг. Энэхүү шимтгэлийн орлого нь СТОУС-ын дагуу үр ашигт хүүгийн нэг хэсэг бөгөөд тухайн зээлийн гэрээний хугацаанд хойшлогдон бүртгэгддэг.

**6 Удирдлагын болон үйл ажиллагааны зардал**

	Тодруулга	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 10 сарын 31 мян.төг (аудитлаг- даагүй)
Цалингийн зардал		145,666	-
Зар сурталчилгаа, маркетингийн үйлчилгээний зардал		127,860	-
Мэргэжлийн үйлчилгээний зардал		55,854	300
ЛэндМН системийн засвар үйлчилгээний зардал (Тодруулга 20)		35,153	-
Биет бус хөрөнгийн хорогдол	11	24,790	-
Бусад сангийн зардал	15	15,805	-
Түрээсийн зардал		15,693	-
Нийгмийн даатгалын шимтгэл		15,687	-
Банкны шимтгэл		10,697	20
Засвар үйлчилгээний зардал		8,359	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл	12	8,317	403
Бусад зардал		22,677	386
<b>Нийт удирдлагын болон үйл ажиллагааны зардал</b>		<b>486,558</b>	<b>1,109</b>

**7 Орлогын албан татвар**

Тухайн хугацаанд орлого, үр дүнгийн тайланд бүртгэгдсэн орлогын албан татварын зардлыг дор үзүүлэв:

	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 10 сарын 31 мян.төг (аудитлаг- даагүй)
Тайлант хугацааны орлогын албан татвар	1,343	119
<b>Тайлант хугацааны орлогын татварын зардал</b>	<b>1,343</b>	<b>119</b>

Компани орлогын албан татварын зардлыг санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийг орлогын татвар ногдохгүй орлого болон татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлаар тохируулга хийх замаар тооцон бүртгэдэг. Компани нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу 3 тэрбум (2016: 3 тэрбум) хүртэлх төгрөгний албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 3 тэрбум (2016: 3 тэрбум) төгрөгнөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар (2016: 25 хувь) орлогын албан татвар төлдөг.

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Компанид хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв.

	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 10 сарын 31 мян.төг (аудитлаг- даагүй)
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(71,472)</b>	<b>837</b>
Хуулиар заасан 10 хувиар тооцсон татварын зардал (2016: 10%)	(7,147)	84
Татварын нөлөө:		
- Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох хүүгийн орлого	1,343	119
- Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	2,286	-
- Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татвар	4,861	(84)
<b>Тайлант хугацааны орлогын албан татварын зардал</b>	<b>1,343</b>	<b>119</b>

СТОУС болон Монгол Улсын татварын хууль, тогтоомжуудын хооронд тайлагналын зорилгоос үүдэн санхүүгийн тайлангийн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар тооцох суурь хооронд түр зөрүү үүсдэг.

Компани энэ тайлант хугацаанд 48,610 мянган төгрөгийн татварын алдагдалтай (2016: 0) байсан ба энэ нь дараагийн 2 санхүүгийн жилийн татвар ногдох орлогод шилжүүлэн тооцох боломжтой. Шилжүүлсэн алдагдлын дүн нь тухайн тайлант хугацааны татварын орлогын дүнгийн 50 хувиас хэтрэх ёсгүй.

Компани дараагийн 2 санхүүгийн жилд 2017 оны татварын алдагдлыг шилжүүлэн тооцох хэмжээний татварын орлого олох эсэх нь тодорхой бус тул хойшлогдсон татварын хөрөнгө үүсгээгүй.

Компанийн 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны орлогын албан татварын бодит хувь нь (1.88%) (2016: 14.22%) байв.

**8 Нэгж хувьцаанд ногдох ашиг**

Компанид нэгж хувьцаанд ногдох ашгийг шингэрүүлэх, энгийн хувьцаанд хөрвөх боломжтой санхүүгийн хэрэглүүр байхгүй. Тиймээс нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрүүлсэн ашгийн дүн адилхан. Тайлангийн дараа хийгдсэн хувьцаа хуваалтаар тохируулагдсан нэгж хувьцаанд ногдох ашиг дараах байдалтай байна:

	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 10 сарын 31 мян.төг (аудитлаг- даагүй)
<u>Ашиг/(алдагдал)</u>		
Тайлант хугацааны цэвэр ашиг/(алдагдал) буюу Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох нийт дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)	(72,815)	718
	<b>Хувьцааны тоо</b>	
	2017 оны 10 сарын 31	2016 оны 10 сарын 31 (аудитлаг- даагүй)
Үндсэн болон хорогдуулсан нэгж хувьцаанд ногдох энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо	900,990	400,000
Тайлангийн дараах хувьцаа хуваалтын нөлөө (Тодруулга 21)	98,085,149	39,600,000
	99,075,908	40,000,000
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)</b>	<b>MNT</b>	<b>MNT</b>
Компанийн хувьцаа эзэмшигчдийн тайлант хугацааны:		
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг (алдагдал) (төгрөгөөр)	(0.73)	0.02
Нэгж хувьцаанд ногдох шингэрүүлсэн ашиг (алдагдал) (төгрөгөөр)	(0.73)	0.02

**9 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө**

	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 12 сарын 31 мян.төг
Кассанд байгаа бэлэн мөнгө	362	1,174
Банкны харилцах данс	319,681	506,765
<b>Нийт мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>320,043</b>	<b>507,939</b>

Банкны харилцах дансан дахь мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нь Монголын арилжааны банкуудад байршсан харилцах дансны үлдэгдэл бөгөөд барьцаалагдаагүй болно. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны дүнтэй нь ойролцоо байна. Бүх мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг хугацаа хэтрээгүй, үнэ цэнэ буураагүй гэж ангилсан. 2017 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар банкны харилцах дансан дахь мөнгөн хөрөнгийн жилийн хүү нь 0.0%-9.75% байна (2016 оны 12 дугаар сарын 31: 0.0%-3.7%).

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нь бүгд Монгол төгрөгөөр байршсан.

**10 Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа**

	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 12 сарын 31 мян.төг
ЛэндМН системээр олгогдсон зээл	2,118,260	20,919
Бусад зээл-Түлхүүр удирдлагад олгосон зээл (Тодруулга 20)	3,600	103,241
<b>Харилцагчдад олгосон нийт зээл болон урьдчилгаа</b>	<b>2,121,860</b>	<b>124,160</b>
Хасах нь: Зээлийн үнэ цэнийн бууралтын сан	(11,590)	-
<b>Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа</b>	<b>2,110,270</b>	<b>124,160</b>

Компанийн бизнесийн загварын дагуу, ЛэндМН технологийг ашиглан зээл авсан зээлдэгчид нь богино хугацаанд хэрэглээгээ санхүүжүүлэх зорилготой хувь хүмүүс байдаг.

Компани нь зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцохдоо зээлийн багцыг бүлгийн болон тусгай үнэлгээний ангилалд хувааж үздэг. Үнийн дүн том эсвэл төлөгдөх хугацаа нь их хугацаагаар хэтэрсэн зээлийн авлагуудыг тусгай үнэлгээний ангилалд оруулан, үнэ цэнийн бууралтыг нь хэмжинэ. Бусад зээлүүд нь бүлгийн үнэлгээний ангилалруу ангилагдана. Тусгай үнэлгээний ангилалд буй зээлийн авлагад үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг тогтоохдоо авлагуудын төлөгдөх хугацаа нь хэтэрсэн эсэхийг нэн түрүүнд харгалзана. Мөн үнэ цэнийн бууралтыг үүсгэх нөхцөл байдал үүссэн эсэхийг шалгаж, тэдгээр нь хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлсөн эсэхийг харгалзана. 2017 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар тусгай үнэлгээний ангилалд багтсан зээлийн авлагуудад зээлийн үнэ цэнэ бууралтын сан үүсгэх шаардлагагүй гэж дүгнэсэн ба хүлээн зөвшөөрсөн зээлийн үнэ цэнэ бууралтын сан нь бүлгийн үнэлгээний ангилалд багтсан зээлийн авлагууд дээр үүсгэсэн болно.

ЛэндМН системийг ашиглан, хэрэглэгчдэд олгосон зээлийн үнэ цэнийн бууралтын санд гарсан өөрчлөлтүүдийг дор үзүүлэв:

	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 12 сарын 31 мян.төг
1-р сарын 1-ний байдлаар	-	-
Тайлант хугацааны өөрчлөлт	11,590	-
10-р сарын 31/12-р сарын 31-ний байдлаар	11,590	-

**11 Биет бус хөрөнгө**

	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 12 сарын 31 мян.төг
<b>Өртөг</b>		
1-р сарын 1-нээр	300,000	-
Нэмэгдэл	-	300,000
<b>Нийт</b>	<b>300,000</b>	<b>300,000</b>
<b>Хуримтлагдсан хорогдол</b>		
1-р сарын 1-нээр	5,000	-
Тайлант хугацааны хорогдол (Тодруулга 6)	24,790	5,000
<b>Нийт</b>	<b>29,790</b>	<b>5,000</b>
<b>Дансны цэвэр дүн</b>	<b>270,210</b>	<b>295,000</b>

Компанийн биет бус хөрөнгө нь 2016 оны 12 дугаар сард шууд толгой компани болох Анд Системс ХХК-с худалдаж авсан, зээлийн үйл ажиллагаа явуулах зориулалт бүхий ЛэндМН технологийг Монгол улсын нутаг дэвсгэрт ашиглах тусгай эрх бүхий ливензээс бүрдэнэ. ЛэндМН технологи нь харилцагчийг бүртгэх, зээлийн шийдвэр гаргах, зээл олгох, төлөлт хийх, тайлагнах, харилцагчид техникийн тусламж үйлчилгээ үзүүлэх, болон ЛэндМН апплэкшнаас бүрдэнэ. ЛэндМН системийн тусгай ливензийг авахад 1 удаагийн 300,000 мянган төгрөг төлөх ёстой ба Компани энэ төлбөрийг бүрэн төлж барагдуулсан.

Ливенз нь анх 2016 оны 12 дугаар сард туршилтын зорилгоор 5 жилийн хугацаатай олгогдсон ба туршилтын хугацаа 2017 оны 7 сарын 1-ний өдрөөр дуусгавар болж, ливензийн хугацааг 2016 оны 12 дугаар сараас хойш нийт 50 жил болгож, нэмэлт төлбөргүйгээр сунгасан. 2 тал харилцан тохиролцсон үед эсвэл Компани зээлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлгүй болсноос бусад тохиолдолд ливензийн гэрээг цуцлах нөхцөл байхгүй. Ливензийн хугацаа хэдийгээр 50 жил боловч, удирдлага ливензийн ашиглалтын хугацааг 10 жил гэж дүнгэж байгаа тул, ливензийг 10 жилээр хорогдуулан бүртгэж байгаа.

## 12 Үндсэн хөрөнгө

	Тавилга, оффисын хэрэгсэл мян.төг	Компьютер, тоног төхөөрөмж мян.төг	Нийт мян.төг
<b>2017 оны 10 дугаар сарын 31</b>			
<b>Өртөг</b>			
2017 оны 1-р сарын 1-нээр	19,312	4,764	24,076
Нэмэгдсэн	18,312	31,554	49,866
Данснаас хассан	-	(330)	(330)
2017 оны 10-р сарын 31-нээр	<u>37,624</u>	<u>35,988</u>	<u>73,612</u>
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>			
2017 оны 1-р сарын 1-нээр	274	729	1,003
Тайлант хугацааны элэгдэл (Тодруулга 6)	2,377	5,940	8,317
Данснаас хассан	-	(45)	(45)
2017 оны 10-р сарын 31-нээр	<u>2,651</u>	<u>6,624</u>	<u>9,275</u>
<b>Дансны цэвэр дүн</b>	<u>34,973</u>	<u>29,364</u>	<u>64,337</u>
<b>2016 оны 12 дугаар сарын 31</b>			
<b>Өртөг</b>			
2016 оны 1-р сарын 1-нээр	940	1,329	2,269
Нэмэгдсэн	18,372	3,435	21,807
Данснаас хассан	-	-	-
2016 оны 12 сарын 31-нээр	<u>19,312</u>	<u>4,764</u>	<u>24,076</u>
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>			
2016 оны 1-р сарын 1-нээр	71	332	403
Тайлант жилийн элэгдэл	203	397	600
2016 оны 12-р сарын 31-нээр	<u>274</u>	<u>729</u>	<u>1,003</u>
<b>Дансны цэвэр дүн</b>	<u>19,038</u>	<u>4,035</u>	<u>23,073</u>

Үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулсан зээлийн хүүгийн зардал байхгүй. Мөн өр төлбөрийн барьцаанд байгаа үндсэн хөрөнгө байхгүй.

## 13 Бусад хөрөнгө

	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 12 сарын 31 мян.төг (Дахин тайлагнасан)
Бусад авлага	851	-
Холбоотой талуудаас авах авлага (Тодруулга 20)	30,000	14,700
Урьдчилж төлсөн төлбөр	13,670	-
	<u>44,521</u>	<u>14,700</u>

**14 Хаалттай бондын өглөг**

Компанийн хувьцаа эзэмшигчид 2017 оны 10 дугаар сарын 30-нд Компанийг 1,000,000 ширхэг, тус бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 18 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай бонд гаргах шийдвэр гарган баталсан. Үүний дагуу 2017 оны 10 дугаар сарын 31-нд Компанийн 300,000 ширхэг хаалттай бондыг шууд толгой компани болох Анд Системс ХХК худалдан авсан. Хаалттай бонд нь барьцаагүй. Мөн уг хаалттай бондыг олон нийтэд худалдахаар санал болгоогүй бөгөөд аль нэг хөрөнгийн зах зээл дээр бүртгэлгүй, худалдагддаггүй учир “хаалттай” гэж нэрлэсэн. Хаалттай бондын хүү нь хугацааны туршид хуримтлагдан, хугацааны эцэст төлөгдөх нөхцөлтэй. 2017 оны 10 дугаар сарын 31-ний хаалттай бондын дансны дүнд 200 мянган төгрөгний хүү хуримтлагдан бүртгэгдсэн.

**15 Бусад өр төлбөр**

	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 12 сарын 31 мян.төг (Дахин тайлагнасан)
<b>Бусад санхүүгийн өр төлбөр</b>		
Шууд толгой компанид өгөх өглөг (Тодруулга 20)	-	153,000
Гуравдагч талд өгөх өглөг	41,813	1,600
<b>Нийт бусад санхүүгийн өр төлбөр</b>	<b>41,813</b>	<b>154,600</b>
<b>Бусад санхүүгийн бус өр төлбөр</b>		
Орлогын албан татвараас бусад татварын өглөг	30,000	15,492
Ирээдүйн болзошгүй татварын өр төлбөрийн сан	15,805	-
	<b>45,805</b>	<b>15,492</b>
<b>Нийт бусад өр төлбөр</b>	<b>87,618</b>	<b>170,092</b>

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх шууд толгой компанид өгөх өглөг нь Анд Системс ХХК-д өгөх, 2016 онд худалдаж авсан лицензийн төлбөрийн үлдэгдэл бөгөөд Компани энэ үлдэгдлийг 2017 онд бүрэн төлж барагдуулсан.

Бусад өр төлбөрийн дуусгавар хугацааны шинжилгээг Тодруулга 17-с харна уу.

Ирээдүйн болзошгүй татварын өр төлбөрийн сангийн хөдөлгөөнийг толилуулав:

	31.10.2017 мян.төг	31.12.2016 MNT'000 мян.төг
1-р сарын 1-ний байдлаар	-	-
Тайлант хугацаанд тооцоолсон сан (Тодруулга 6)	15,805	-
10-р сарын 31/12-р сарын 31-ний байдлаар	<b>15,805</b>	<b>-</b>

**16 Хувьцаат капитал**

Компани нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, хязгаарлагдмал хариуцагатай компани юм. Нийт зөвшөөрөгдсөн бөгөөд гаргасан энгийн хувьцааны тоо ширхэг нь 2,500,000 (2016: 800,000) бөгөөд нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1,000 төгрөг (2016: 1,000 төгрөг) болно. Гаргасан бүх хувьцаа нь бүрэн төлөгдсөн. Нэгж энгийн хувьцаа 1 саналын эрхтэй.

## 16 Хувьцаат капитал (Үргэлжлэл)

	Нийт хувьцааны тоо	Хувьцаат капитал мян.төг
2016 оны 1-р сарын 1-нээр	400,000	400,000
Шинээр нэмж гаргасан хувьцаа	400,000	400,000
2016 оны 12-р сарын 31-нээр	<u>800,000</u>	<u>800,000</u>
Шинээр нэмж гаргасан хувьцаа	1,700,000	1,700,000
2017 оны 10-р сарын 31-нээр	<u>2,500,000</u>	<u>2,500,000</u>

Монгол улсын иргэн Гаравсүрэнгийн Идэрмаа нь 2017 оны 7-р сарын 28-нд өөрийн эзэмшдэг, Компанийн 800,000 ширхэг энгийн хувьцааг Анд Системс ХХК-д шилжүүлсэн. Үүний дараа 2017 оны 9-р сарын 27-нд Компани шинээр тус бүр нь 1,000 төгрөгний нэрлэсэн үнэтэй, 1,700,000 ширхэг энгийн хувьцаа гаргасан ба гаргасан бүх хувьцааг Анд Системс ХХК худалдан авч, төлбөрийг мөнгөөр бүрэн төлсөн. Компанийн шууд толгой компани нь Анд Системс ХХК бөгөөд эцсийн толгой компани нь Сингапур Улсад бүртгэлтэй, финтек гарааны компани болох Анд Глобал Пте.Лтд юм. Тайлант хугацааны дараах, хувьцаат капиталд гарсан өөрчлөлтүүдийг Тайлагналын өдрийн дараах үйл явдлын тодруулгаас харна уу.

Хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн эзэмшлийн хувийг доорх хүснэгтээр харуулав:

	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 12 сарын 31 мян.төг
Анд Системс ХХК	100.0%	-
Иргэн Г.Идэрмаа	-	100.0%
	<u>100.0%</u>	<u>100.0%</u>

## 17 Санхүүгийн Эрсдлийн Удирдлага

## 1. Танилцуулга

Компанийн үйл ажиллагаанд эрсдэл учрах нь зайлшгүй бөгөөд эдгээр эрсдэлд зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, болон үйл ажиллагааны эрсдэл багтах ба уг эрсдлүүдийг Компанийн Гүйцэтгэх захирал удирдан зохицуулна. Эрсдлийн удирдлагын үндсэн зорилго нь эрсдлийг тогтмол тодорхойлж, хэмжиж, хянах ба ингэснээр эрсдлийг хангалттай хэмжээнд нөхөх өгөөжийг өгөх бизнесийн сегментрүү хөрөнгө оруулах, Компанийн хөрөнгө оруулалтын эрсдлийг тохируулсан өгөөжийг боломжит хамгийн их хэмжээнд барих явдал юм. Эрсдлийн удирдлагын дээрх процесс нь Компанийн тогтвортой хөгжилд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд Компанийн гишүүн бүр өөр өөрсдийн ажил үүргийн хүрээндэх эрсдэлд хариуцлагатай хандах ёстой.

Бие даасан эрсдлийн удирдлагад байгаль орчин, техник технологи болон эдийн засгийн салбарын эрсдлүүд хамаарахгүй бөгөөд тэдгээрийг Компанийн стратеги болон бизнес төлөвлөгөөгөөр зохицуулна.

Компани нь эрсдлийн удирдлагын албан ёсны нэгдсэн бодлоготой бөгөөд энэ бодлого нь эрсдлийг арилгах бус, эрсдэл болон өгөөжийн харьцааг хамгийн ашигтай хэмжээнд барих явдал юм. Эрсдлийн удирдлагын алба ёсны бодлоготой байснаар:

## 17 Санхүүгийн Эрсдлийн Удирдлага (Үргэлжлэл)

- (i) Эрсдлийг удирдах гишүүд нь эрсдлийн удирдлагын шаардлага болон хэмжилтийн системийн талаар бүрэн ойлголттой байна;
- (ii) Хөрөнгийг хуваарилан зарцуулахдаа эрсдлийг тооцоолно;
- (iii) Компанийн үйл ажиллагааны чиглэл нь авч чадах/хүлээн зөвшөөрөх эрсдлийн хэмжээтэй уялдана.

### 2. Эрсдлийн удирдлагын бүтэц

Компанийн эрсдлийн удирдлагыг одоогоор Гүйцэтгэх захирал ерөнхийд нь хариуцан ажиллаж байгаа бөгөөд үүний хүрээнд Гүйцэтгэх захирал эрсдлийн бодлого болон авч чадах/хүлээн зөвшөөрөх эрсдлийг тусгасан зээлийн эрсдлийн бодлогыг тус тус баталдаг. Компани одоогоор Захирлуудын Зөвлөлөө байгуулж, гишүүдийг томилох шатандаа явж байгаа бөгөөд томилогдсон гишүүд нь Компанийн эрсдлийн удирдлагын бүтцийг бүхэлд нь төлөвлөн, зохион байгуулах Эрсдэл хариуцсан захирлыг томилох болно. Шинээр томилогдох Захирлуудын зөвлөл нь компанийн дотоод аудиторыг мөн томилно.

### 3. Зээлийн эрсдэл

Компанийн үндсэн зээлийн эрсдэл нь одоо явуулж буй зээлийн үйл ажиллагааны үр дүнд олгосон зээлүүд нь эргэн төлөгдөхгүй байх эрсдэл юм. Зээлийн эрсдэл нь 1) зээлийн лимитийг тогтоон, батлах үе шат, болон 2) зээл олголтын дараах гүйцэтгэлийг хянах үе шатууд дээр үүсэж болно. Зээлийн лимитийг тогтоон, батлах үе шат дээр ЛэндМН системийн кредит оноог тогтоох модуль нь зээлдэгчийн кредит оноог буруу гаргаснаар тухайн зээлдэгчийн зээлийн лимит болон шимтгэлийн дүнг буруу тогтоох явдлуудаас үүдэн зээлийн эрсдэл үүсэж болно. ЛэндМН системийн кредит оноог тогтоох уг модуль нь өмнөх зээлүүдийн хугацаа хэтэрсэн байдал болон хугацаа хэтэрсэн төлбөр зэрэг түүхэн мэдээллүүд дээр тулгуурлан, процессоо автоматаар засаж сайжруулдаг алгоритм бүхий модуль юм. Уг модуль нь шинэ мэдээлэл системд орж ирэх бүрт зээлдэгчдийн кредит оноог автоматаар шинэчлэж, дараа дараагийнхаа кредит оноог тогтоох алгоритмаа шинэчлэн засах бүтэц бүхий өөрөө өөрийгөө автоматаар засаж сайжруулдаг систем юм. Компанийн удирдлагууд зөвхөн зээлийн лимитийн дүнгүүдийн хязгаар болон шимтгэлийн түвшинг системд оруулж өгөх ба ЛэндМН систем нь өөрөө автоматаар зээлийн шийдвэрээ гаргаж, кредит оноог тогтоох алгоритмаа улам сайжруулаад явдаг байна. Компани хугацаа хэтэрсэн зээлүүдийг хугацаа хэтэрсэн хоногоор нь (1, 30, 60, 90 хоног) тус тус багцлан, тэдгээрийн дүнг зорилтот хувьтай харьцуулан, хянаж явдаг.

Компанийн зээлийн эрсдэл нь ЛэндМН систем кредит оноог тогтоогоод, зээл олгосны дараа бас үүсэж болно. Авлага хариуцсан алба болон Дуудлагын тусламж үйлчилгээний төвийн багийнхан хамтдаа зээлдэгчдийн төлбөр төлөлтийн байдал, өөрчлөлт болон хугацаа хэтэрсэн зээлийг өдөр тутам хянадаг.

Авлага хариуцсан алба нь ЛэндМН системийн хугацаа хэтэрсэн зээлүүдийг ялган, мэдэгдэх үүрэг бүхий модуль нь зөв ажиллаж байгааг шалгах үүрэгтэй бөгөөд тухайн модулийн мэдээллийг зээлдэгчийн эргэн төлөлтийн байдал өөрчлөгдөх бүрт шинэчлэнэ. Дуудлагын тусламж үйлчилгээний төв нь авлага хариуцсан албаны шууд удирдлаган дор ажиллах ба уг төв нь харилцагчдад зээлийн эргэн төлөлтөн дээр үнэн зөв мэдээлэл, тусламж зөвлөгөөг түргэн шуурхай үзүүлдэг.

**17 Санхүүгийн Эрсдлийн Удирдлага (Үргэлжлэл)****3. Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

**Ямар нэгэн барьцаа хөрөнгө болон зээлийн сайжруулалтыг харгалзан үзэхгүйгээр өртөж болох зээлийн эрсдлийн хамгийн өндөр түвшин**

Доорх хүснэгтэнд санхүүгийн байдлын тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүдийн өртөж болох зээлийн эрсдлийн хамгийн өндөр түвшинг харуулав. Өртөж болох зээлийн эрсдлийн хамгийн өндөр түвшин нь нийт дүнгээр харагдана.

	<u>Эрсдлийн хамгийн өндөр түвшин</u>	
	<b>31.10.2017</b> мян.төг	<b>31.12.2016</b> мян.төг
Банкин дах бэлэн мөнгө	319,681	506,765
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	2,110,270	124,160
Бусад санхүүгийн хөрөнгө	30,851	14,700
Олгохоор батлагдсан зээл	1,229,305	8,877
	<b>3,690,107</b>	<b>654,502</b>

**Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн сайжруулалт**

Банкин дах бэлэн мөнгө болон харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь барьцаа хөрөнгөөр баталгаажуулаагүй болно

**ЛэндМН ББСБ ХХК**  
**Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2017 оны 10 дугаар сарын 31**

**17 Санхүүгийн Эрсдлийн Удирдлага (Үргэлжлэл)**

**3. Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

Санхүүгийн хөрөнгийн зээлжих чанарын шинжилгээ, бүлгээр:

	Хугацаа хэтрэлгүй, үнэ цэнийн бууралтгүй мян.төг	Хугацаа хэтэрсэн боловч тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралтгүй			90-с дээш хоног хэтэрсэн мян.төг	Бүлгийн үнэлгээгээр үнэ цэнийн бууралт мян.төг	Нийт мян.төг
		30 хоногийн дотор мян.төг	31-60 хоног хэтэрсэн мян.төг	61-90 хоног хэтэрсэн мян.төг			
<b>2017 оны 10-р сарын 31-нээр</b>							
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	320,043	-	-	-	-	-	320,043
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа							
ЛэндМН	2,036,308	57,446	14,233	3,365	(11,590)	2,106,670	
Бусад зээл	3,600	-	-	-	-	3,600	
Холбоотой талаас авах авлага	30,000	-	-	-	-	30,000	
<b>Нийт</b>	<b>2,389,951</b>	<b>57,446</b>	<b>14,233</b>	<b>3,365</b>	<b>(11,590)</b>	<b>2,460,313</b>	
<b>2016 оны 12-р сарын 31-нээр</b>							
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	507,939	-	-	-	-	-	507,939
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа							
ЛэндМН	20,919	-	-	-	-	20,919	
Бусад зээл	103,241	-	-	-	-	103,241	
Холбоотой талаас авах авлага	14,700	-	-	-	-	14,700	
<b>Нийт</b>	<b>646,799</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>646,799</b>	

**ЛэндМН ББСБ ХХК**  
**Санхүүгийн Тайлангийн Тодруулууд – 2017 оны 10 дугаар сарын 31**

**17 Санхүүгийн Эрсдлийн Удирдлага (Үргэлжлэл)**

**4. Төлбөрийн чадварын эрсдэл**

Компани нь үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд өдөр бүр зах зээлийн эрэлт нь есөн нэмэгдэж байгаа зээлийн бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд олгоход болон компанийн өр төлбөрийг барагдуулахад шаардлагатай, хангалттай хэмжээний санхүүжилтийн эх үүсвэртэй байх явдал нь төлбөрийн чадварын эрсдлийн удирдлагын гол зорилго юм. Хэрэглэгчдэд олгох зээлийн бүтээгдэхүүний гол санхүүжилтийг шууд толгой компаниас зээлээр эсвэл өмчөөр хөрөнгө оруулалт хэлбэрээр татан авдаг. Компанийн үйл ажиллагаа нь эрчимтэй өргөжиж байгаа тул, гуравдагч талууд болох арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллагууд, болон хувийн хөрөнгийн сан гэх мэт бусад хөрөнгө оруулагч байгууллагуудаас зээлийн санхүүжилт татахаар хэлэлцээрүүд хийгдэж байна.

**Санхүүгийн өр төлбөрийн дуусвар хугацааны шинжилгээг дор үзүүлэв:**

Дараах хүснэгтэнд 2016 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 10 дугаар сарын 31-нээрх Компанийн санхүүгийн өр төлбөрийн дуусвар хугацааны шинжилгээг гэрээнд тусгагдсан дискаунтчилагдаагүй дүнгүүд дээр тулгуурлан үзүүлэв. Доорх хүснэгтэнд Компанийн хадгаламжийн түүх дээр үндэслэгдэн хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний дүнг хамруулаагүй болно.

	Нэхэмжилсэн үед					3 сарын дотор			6-12 сарын дотор		1-5 жилийн дотор		5-с дээш жилийн дараа		Нийт санхүүгийн өр төлбөр (Дискаунтчилаг даагүй) мян.төг
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг		
<b>2017 оны 10-р сарын 31-нээр</b>															
Олгохоор батлагдсан зээл	1,229,305	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1,229,305
Бондын зээлийн өглөг	-	-	-	-	-	-	-	-	354,000	-	-	-	-	-	354,000
Бусад өр төлбөр	453	41,360	41,360	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	41,813
	<b>1,229,758</b>	<b>41,360</b>	<b>41,360</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>354,000</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1,625,118</b>
<b>2016 оны 12-р сарын 31-нээр</b>															
Олгохоор батлагдсан зээл	8,877	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	8,877
Бусад өр төлбөр	154,600	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	154,600
	<b>163,477</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>163,477</b>

Компанийн удирдлага нь олгохоор батлагдсан бүх зээл нь богино хугацаанд олгогдохгүй гэж үзэж байна. Санхүүгийн тайлангийн тодруулга 21-ээс тус үүргийг биелүүлэхтэй холбоотой өр төлбөр болон өмчийн нэмэлт санхүүжилтийн мэдээллийг харна уу.

## 17 Санхүүгийн Эрсдлийн Удирдлага (Үргэлжлэл)

### 5. Зах зээлийн эрсдэл

Санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал нь хүүгийн түвшний өөрчлөлт, эсвэл гадаад валютын ханшийн өөрчлөлт гэх мэт зах зээлийн үнийн өөрчлөлтөөс болж өөрчлөгдөх эрсдлийг зах зээлийн эрсдэл гэнэ. Компани уг эрсдлийг боломжит нөлөөллийн дүн шинжилгээгээр хянан зохицуулдаг ба компанийн зээлийн авлагууд нь богино хугацаатай тул зах зээлийн томоохон эрсдэл Компанид байхгүй.

#### Зээлийн авлагууд урьдчилж төлөгдөх эрсдэл

Харилцагч зээлээ хугацаанаас нь өмнө, урьдчилан төлөх тохиолдолд, ирээдүйн хүүг бүтнээр нь төлөх нөхцөлтэй тул зээлийн авлагууд урьдчилж төлөгдөх эрсдэл байхгүй.

#### Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл нь системийн алдаа, хүний алдаа, залилан, болон гадны нөлөөллийн улмаас алдагдал хүлээх эрсдэл юм. Уг эрсдлийг удирдан хянахгүй бол, компанийн үйл ажиллагаа доголдох бөгөөд ингэснээр компанийн нэр хүнд муудах, хуулийн хариуцлага хүлээх, санхүүгийн алдагдалд орох гэх мэт сөрөг үр дагавартай. Компани нь үйл ажиллагааны эрсдлийг бүхэлд арилгаж чадахгүй ч, эрсдлийн удирдлагын нэгдсэн бодлогыг чанд мөрдөх, үйлчилгээний баг болон ерөнхий үйл ажиллагааны багын ажил үүргийг тусгаарлах, системийн аюулгүй байдлыг бүрэн хангах, болон ажиллагсдын ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэх замаар үйл ажиллагааны эрсдлийг удирдан, багасган ажиллаж байна.

## 18 Болзошгүй өр төлбөр ба Үүрэг хариуцлага

**Зарга, маргаан.** Компани бизнесийн хэвийн үйл ажиллагааныхаа хүрээнд өөрийн эсрэг нэхэмжлэл хүлээн авах магадлал бий. Удирдлага өөрсдийн үнэлэмж, тооцоо, компанийн мэргэжилтнүүдийн зөвлөмжид үндэслэн зарга, нэхэмжлэлтэй холбоотой материаллаг хохирол хүлээхгүй гэж үзэж байгаа тул санхүүгийн тайланд үүнтэй холбогдуулж аливаа сан хүлээн зөвшөөрөөгүй болно.

**Татварын хууль, зохицуулалт.** Монгол улсын татвар, валют болон гаалийн зохицуулалттай холбоотой хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах, мөн үе үе өөрчлөгдөх болзошгүй байдаг. Удирдлагын үнэлэмж, тайлбараар хууль журмыг ажил гүйлгээ, үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байдлыг холбогдох төрийн албаны зүгээс хүлээн зөвшөөрөхгүй байх тохиолдол гардаг.

Монгол Улсын татварын алба хууль тогтоомжийг тайлбарлан үнэлэхдээ илүү хатуу байр суурь баримтлах талтай байдаг ба өмнө нь санал зөрөлдөж байгаагүй үйл ажиллагаа, ажил гүйлгээг татварын алба хожим нь үгүйсгэх боломжтой. Үүнээс үүдэж томоохон хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алдангийг ногдуулах магадлалтай байдаг. Татварын хяналт шалгалт орох үед өмнөх таван жилийн татварыг шалгадаг тул эдгээр татварын жилүүд хяналт шалгалтанд нээлттэй хэвээр үлддэг. Зарим тохиолдолд татварын хяналт шалгалтанд илүү урт хугацааг хамруулах явдал байдаг.

Монгол Улсын татварын хууль журам, зохицуулалтаар нэмэгдсэн өртгийн албан татвар, суутган татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үнэ шилжүүлэлт болон бусад зүйлстэй холбоотой зарим зүйл, заалт, асуудлаар тодорхой зааварчилгаа байдаггүй. Зарим нэг тохиолдолд удирдлага хуулийн энэхүү тодорхой бус зүйлсийн тухайд компанийн татварын ерөнхий хувийг бууруулах чиглэлд тайлбарлан хэрэглэдэг. Сүүлийн үед явагдсан захиргааны болон шүүхийн практик шинэчлэлийн үр дүнд дээрх тодорхой бус байдлын талаарх байр суурь илүү их хатуу хяналт шалгалтанд өртөх талтай болсон. Хэдийгээр татварын албанаас тавигдах шаардлага компанийн санхүүгийн байдал болон нийт үйл ажиллагаанд материаллаг нөлөө үзүүлэх боломжтой боловч, холбогдох нөлөөллийг найдвартай хэмжих боломжгүй юм. Компанийн удирдлага холбогдох хууль тогтоомжийг зохистойгоор тайлбарлан хэрэглэсэн гэж үзэж байгаа бөгөөд компани татвар болон бусад хууль тогтоомжийн талаарх компанийн байр сууриа тогтвортой хадгалах болно.

**18 Болзошгүй өр төлбөр болон Үүрэг хариуцлага (Үргэлжлэл)**

Удирдлага одоогоор татвар болон бусад хууль тогтоомжоос үүсэх эрсдэлийг бага гэж дүгнэж байгаа бөгөөд татварын эрсдэлийг цаашид тогтмол эргэн харж үнэлэх бөгөөд дээрх дүгнэлт нь одоогоор урьдчилан мэдэгдэх боломжгүй ирээдүйн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж магадгүй. Компанийн удирдлага 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар болон 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар татварын тодорхой бус байдалтай холбоотой сан хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзэж байна.

**Олгохоор баталсан зээлийн үүрэг.** Энэхүү үүргийн үндсэн зорилго нь харилцагчдад шаардлагатай үед нь санхүүжилтын эх үүсвэр бэлэн байлгахад оршино. Зээл олгохоор амласан амлалт нь харилцагчийн ЛэндМН системээс түүнд олгохоор батлагдсан нийт зээлийн ашиглаагүй байгаа хэсгийг хэлнэ. Олгохоор баталсан зээлийн үүргийн эрсдлийн хувьд, Компани нийт дүнгээр зээлийн эрсдэлд орж болно. Гэхдээ харилцагч тусгайлан заасан зээлийн нөхцлүүдийг биелүүлсэн нөхцөлд зээлийг бодитоор олгох болзолтой учир, зээлийн эрсдлийн дүн нь олгохоор баталсан зээлийн үүргийн нийт дүнгээс бага байна. 2017 оны 10 сарын 31-ний байдлаар Компанийн олгохоор баталсан зээлийн үүргийн нийт дүн нь 1,229,305 мянган төгрөг байна (2016 оны 12 сарын 31-нд 8,877 мянган төгрөг байсан).

**19 Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт****Бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан аргууд болон үнэлэмжүүд**

Бодит үнэ цэнийг дотор нь түвшингээр нь ангилан тодорхойлох ба эдгээр түвшинг дараах байдлаар тодорхойлно. Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 1-р түвшин, тухайн хөрөнгө болон өр төлбөртэй холбоотой шууд (үнэ) болон шууд бус (үнийг ашиглан) боломжит өгөгдлүүдийг ашиглан, үнэлгээний аргуудаар бодит үнэ цэнийг тооцоолон гаргасан бол 2-р түвшин, зах зээл дээрх бэлэн өгөгдлүүд дээр бус зах зээл дээр мэдэгдэхгүй байгаа өгөгдлүүдийг илүү тулгаарлан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 3-р түвшингийн бодит үнэ цэнэ гэж тус тус ангилна. Удирдлага санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн түвшингээр нь ангилахдаа өөрсдийн үнэлэмжийг ашиглана. Хэрэв бодит үнэ цэнийг тодорхойлоход тохируулга ихээхэн хийгдэх өгөгдлийг ашиглаж байгаа бол тухайн хэмжилт нь 3-р түвшинд хийгдэж байна гэсэн үг. Ашиглаж буй өгөгдлийн ач холбогдлыг бодит үнэ цэнийн хэмжилттэй бүхлээр нь харьцуулан авч үзнэ.

Компанийн бүх санхүүгийн хэрэглүүрүүд нь богино хугацаатай учир, тэдгээрийн бодит үнэ цэнэ нь дансны дүнтэй ойролцоо байна.

**20 Холбоотой талын ажил гүйлгээ**

Гол удирдах ажилтнуудын нийт олговрыг доорх хүснэгтээр харуулав:

	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 10 сарын 31 мян.төг (Аудитлаг- даагүй)
Цалин	28,521	-
Эрүүл мэнд, нийгмийн даатгал	3,138	-
	<b>31,669</b>	<b>-</b>

**20 Холбоотой талын ажил гүйлгээ (Үргэлжлэл)**

2017 оны 10 дугаар сарын 31 болон 2016 оны 12 дугаар сарын 31-нээрх холбоотой талуудын үлдэгдлийг доорх хүснэгтээр харуулав:

	Тод- руулга	2017 оны 10 сарын 31 мян.төг	2016 оны 12 сарын 31 мян.төг (Дахин тайлагнасан)
Компанийн гол удирдах ажилтнуудад олгосон зээл	(i)	3,600	4,172
Компанийн гол удирдах ажилтнуудад ЛэндМН системээр олгосон зээл	(ii)	2,155	1,540
Хамаатай талд өгөх өглөг (Тодруулга 15)	(iii)	-	153,000
Хамаатай талаас авах авлага (Тодруулга 13)	(v)	30,000	14,700
Хамаатай талд өгөх өглөг (Хаалттай бонд Тодруулга 14)	(iv)	300,200	-
		<b>335,955</b>	<b>173,412</b>

2017 оны 10 дугаар сарын 31 болон 2016 оны 10 дугаар сарын 31-р дуусгавар болсон 10 сарын тайлант хугацаанд холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний дүнг доорх хүснэгтээр харуулав:

		2017 оны 10 сарын 31 мян.төг	2017 оны 10 сарын 31 мян.төг (Аудитлаг- даагүй)
Олгосон зээлийн хүүгийн орлого	(i), (ii)	1,434	150
Хаалттай бондын өглөгийн хүүгийн зардал	(iv)	3,286	-
ЛэндМН системийн үйлчилгээний төлбөр (Тодруулга 6)	(vi)	35,153	-
		<b>39,873</b>	<b>150</b>

- (i) Компанийн гол удирдах ажилтнуудад олгосон зээл нь хувь хүнд олгосон 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр 3,600 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэг зээл юм. Хувь хүнд олгосон зээл нь барьцаагүй, жилийн 12 хувийн хүүтэй, 11 сарын дотор төлөгдөх нөхцөлтэй.
- (ii) ЛэндМН системээр гол удирдах ажилтнуудад олгосон зээл – Компани 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон 10 сарын хугацаанд 24,556 мянган төгрөгийн зээлийг гол удирдах ажилтнуудад олгосноос 22,401 мян.төгрөг нь бүрэн төлөгдөж, 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр 2,120 мян.төгрөгийн дуусаагүй үлдэгдэлтэй байна. ЛэндМН системийн дуусаагүй зээл нэг сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй, хүүгүй боловч 35 мян.төгрөгийн системийн шимтгэлтэй.
- (iii) Компани 2016 оны 12 дугаар сард өөрийн шууд толгой компани болох Анд Системс ХХК-с Монгол улсын нутаг дэвсгэрт зээлийн үйл ажиллагаа явуулах, ЛэндМН системийг ашиглах тусгай эрх худалдаж авсан. ЛэндМН технологи нь харилцагчийг бүртгэх, зээлийн шийдвэр гаргах, зээл олгох, төлөлт хийх, тайлагнах, харилцагчид техникийн тусламж үйлчилгээ үзүүлэх, болон ЛэндМН апплэкшнаас бүрдэнэ. ЛэндМН системийн тусгай лизенцийг авахад 1 удаагийн 300,000 мянган төгрөг төлсөн. Лиценз нь анх 2016 оны 12 дугаар сард туршилтын зорилгоор 5 жилийн хугацаатай олгогдсон ба туршилтын хугацаа 2017 оны 7 сарын 1-р дуусгавар болж, лицензийн хугацааг 2016 оны 12 дугаар сараас хойш нийт 50 жил болгож, нэмэлт төлбөргүйгээр сунгасан. 2 тал харилцан тохиролцсон үед эсвэл Компани зээлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлгүй болсоноос бусад тохиолдолд лицензийн гэрээг цуцлах нөхцөл байхгүй. 2016 оны 12 сарын 31-ний байдлаар Компани лицензийн төлбөрт нийт 147,000 мянган төгрөг төлсөн ба үлдсэн дүн болох 153,000 мянган төгрөг нь 1 жилийн дотор төлөгдөх нөхцөлтэй байсан.

## 20 Холбоотой талын ажил гүйлгээ (Үргэлжлэл)

- (iv) Санхүүгийн тайлангийн 14-р тодруулга дээр тодруулсанчлан, хамаатай тал болох Анд Системс ХХК-д өгөх хаалттай бондын өглөг нь барьцаагүй, жилийн 18 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай болно. Үүнээс гадна, компани 2017 оны 8 сарын 22нд Анд Системс ХХК-руу дахин хаалттай бонд гаргаж, 345,000 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Энэ бонд нь тус бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 18 хувийн хүүтэй, 3 сарын дотор төлөгдөх нөхцөлтэй, 345,000 ширхэг бонд байсан бөгөөд энэ бондыг 2017 оны 9 сарын 27-нд бүрэн төлж барагдуулсан.
- (v) Хамаатай тал болох Анд Системс ХХК-с авах авлага нь барьцаагүй, хүүгүй, нэхэмжлэсэн үед төлөгдөх нөхцөлтэй.
- (vi) Компани 2017 оны 7 сарын 1-нд Анд Системс ХХК-тай хэрэглэгчдийн кредит оноог тогтоох үйлчилгээ болон ЛендМН системийн засвар үйлчилгээний гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний дагуу Анд Системс ХХК-д сар бүр төлөх дүн нь тухайн сарын зээлийн ажил гүйлгээний тоо ширхэг дээр тулгуурлагддаг.

## 21 Тайлагналын өдрийн дараах үйл явдал

Дараах ажил гүйлгээнүүд нь тайлант хугацааны эцсийн өдөр болон санхүүгийн тайланг хэвлэн нийтлэх зөвшөөрөл олгогдсон өдрийн хооронд явагдсан болно:

1. Компани нь 2017 оны 10-р сарын 30-нд нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 2,000,000 ширхэг энгийн хувьцааг 2,000,000 мянган төгрөгөөр гаргасан бөгөөд энэ хувьцааг шууд толгой компани болох Анд Системс ХХК худалдаж авсан. Дээрх ажил гүйлгээг Санхүүгийн Зохицуулах Хороо 2017 оны 11-р сарын 13-нд зөвшөөрсөн бөгөөд Анд Системс ХХК нь тухайн өдөр хувьцааны төлбөрийг бүрэн төлсөн.
2. Компани нь 2017 оны 11-р сарын 10-нд нэг бүр нь 1,000 төгрөгний нэрлэсэн үнэтэй, сарын 16 хувийн хүүтэй бөгөөд хүүний төлбөрийг улиралд 1 удаа төлөх нөхцөлтэй, 1 жилийн хугацаатай, 1,000,000 ширхэг хаалттай бонд ганд гаргасан. Гаргасан бүх бонд нь эцсийн толгой компанийн нэг хувьцаа эзэмшигчид тухайн өдрөөр борлуулалдсан. Мөн Компани уг өдөр Анд Системс ХХК-д борлуулсан байсан 300,000 ширхэг хаалттай бондыг буцаан худалдаж авсан.
3. Компанийн хувьцаа эзэмшигчид 2017 оны 11-р сарын 14-нд 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нэг энгийн хувьцааг тус бүр нь 10 төгрөгний нэрлэсэн үнэтэй, 100 ширхэг хувьцаанд хуваах шийдвэр гаргасан ба ингэснээр нийт зөвшөөрөгдсөн болон гаргасан (бүрэн төлөгдсөн) энгийн хувьцааны тоо ширхэг 450,000,000 болсон.
4. Компани нь 2017 оны 11-р сарын 30-нд нэг бүр нь 10 төгрөгний нэрлэсэн үнэтэй, 150,000,000 ширхэг энгийн хувьцааг 1,500,000 мянган төгрөгөөр нэмж гаргасан бөгөөд нэмж гаргасан уг хувьцааг шууд толгой компани болох Анд Системс ХХК бүхэлд нь худалдаж авсан. Дээрх ажил гүйлгээний зөвшөөрлийн авахаар Санхүүгийн Зохицуулах Хороонд тухайн өдрөө хүсэлт илгээсэн бөгөөд энэхүү санхүүгийн тайланг хэвлэн нийтлэхийг зөвшөөрсөн өдрийн байдлаар уг зөвшөөрөл хараахан гараагүй байна.
5. Компанийн хувьцаа эзэмшигчид 2017 оны 12-р сарын 1-нд компанийн Захирлуудын зөвлөлийг 5 гишүүнтэйгээр батлав.

Дээрх тайлагналын өдрийн дараах ажил гүйлгээнүүдийн 3 дугаар зүйлээс бусад нь энэхүү санхүүгийн тайланд ямар нэгэн залруулгаар орохгүй гэж компанийн удирдлагууд үзэж байна.

## 22 Өмнөх хугацааны үлдэгдлийн дахин тайлагнал

Холбоотой талын авлага болон суутган татвар дутуу илэрхийлэгдсэн тул харьцуулах үзүүлэлтүүдийг дахин тайлагнав.

Компанийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан дахь залруулгын нөлөөллийг доорхи хүснэгтэнд харуулав.

	2016 оны 12 сарын 31 өмнөх тайлагналаар мян.төг	Дутуу бүртгэсэн холбоотой талын авлага болон суутган татварыг залруулах нь мян.төг	2016 оны 12 сарын 31 дахин тайлагналаар мян.төг
Бусад хөрөнгө	-	14,700	14,700
Бусад өр төлбөр	155,392	14,700	170,092

Энэхүү залруулга нь 2016 оны 1-р сарын 1-ний өдрөөрх эхний үлдэгдэлд нөлөөгүй болно.

## 23 Монгол хэл дээрх орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувиудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувийг дагана.